



Funded by
the European Union



ERASMUS+ RETEACH

REFORMING TEACHER EDUCATION TOWARDS GREEN AND DIGITAL TRANSITION IN MONGOLIA



**OTGONTENGER
UNIVERSITY**
SINCE 1991

ERASMUS+ ХӨТӨЛБӨР

“МОНГОЛ УЛСАД БАГШ БЭЛТГЭХ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ НОГООН БОЛОН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ РҮҮ ШИНЭЧЛЭН НЭВТРҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ДУГААР: 101179222 - RETEACH

**МОНГОЛ УЛСЫН БАГШ БЭЛТГЭХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ
БАЙДЛЫН СУДАЛГАА**

**УЛААНБААТАР ХОТ
2025**



Co-funded by
the European Union



RETEACH
E R A S M U S +

ERASMUS+ ХӨТӨЛБӨР

“МОНГОЛ УЛСАД БАГШ БЭЛТГЭХ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ НОГООН БОЛОН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ РҮҮ ШИНЭЧЛЭН НЭВТРҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

Төслийн дугаар: 101179222 - RETEACH

**МОНГОЛ УЛСЫН БАГШ БЭЛТГЭХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН
СУДАЛГАА**

Энэхүү төсөл нь Европын Комиссын дэмжлэгтэйгээр хамтран санхүүжүүлсэн болно. Уг нийтлэлд зөвхөн зохиогчийн үзэл бодол тусгагдсан бөгөөд үүнд агуулагдсан мэдээллийг ашигласны улмаас үүсэх аливаа үр дагаварт Европын Комисс хариуцлага хүлээхгүй.

Улаанбаатар 2025

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
ОТИС	Отгонтэнгэр их сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
УМС	Удирдлагын мэдээллийн систем
БХТ	Багшийн хөгжлийн төв
ИДС	Их дээд сургууль
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ЕХ	Европын холбоо
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БД	Дэлхийн банк
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага
ЮНИСЕФ	НҮБ-ын Хүүхдийн Сан

ГАРЧИГ

Өмнөтгөл

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БАГШ БЭЛТГЭХ БОЛОН БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ТОГТОЛЦОО СУРГАЛТЫН БОДЛОГО, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1. Монгол улсын боловсролын тогтолцоо	5
2. Боловсролын бүх түвшний байгууллага, түүнд ажиллаж буй багшийн мэдээлэл	6
3. Багш боловсролын талаарх төрийн зорилтууд, ногоон болон дижитал шилжилтийн талаар бодлогын заалт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа	7
4. Багш нарын мэргэшил, чадамжийн хүрээ, төрөл, ангилал	9
5. Багш бэлтгэх боловсролын бодлого	10
6. Багш бэлтгэж буй өнөөгийн байдал	12
7. Багш нарын сонгон шалгаруулалт, үнэлгээ, аттестатчилал, түүний шалгуур үзүүлэлтүүд.....	13
8. Багшийн мэргэжлийн тасралтгүй өсөлтийг хангах албан ба албан бус сургалтын тогтолцоо	15
9. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал ба багшийн чадамжийн уялдаа	17

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БАГШ МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

10. Удиртгал	23
11. Багш бэлтгэж буй хөтөлбөрүүдийн ногоон болон Дижитал байдалд хийсэн шинжилгээ	29

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАГШ НАРТ ТУЛГАМДАЖ БУЙ СОРИЛТ,БЭРХШЭЭЛ

12. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжихэд онлайн болон зайн сургалтын өнөөгийн нөхцөл байдал	47
13. Ерөнхий дүгнэлт.....	52
14. ХАВСРАЛТ.....	54

Өмнөтгөл

Энэхүү “Багш боловсрол сургалтын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны тайланд Дээд боловсролын сургалт, тогтолцооны асуудал, тулгамдаж буй бэрхшээлүүд болон цаашид хэрхэн хөгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно. Тайланг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад багш бэлтгэх боловсролын хөтөлбөрийг ногоон болон дижитал шилжилт рүү шинэчлэн нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулав.

Нийгмийн бүхий л салбарт ажиллах мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын байгууллагад багшлах бүрэлдэхүүний бүтэц, чанар нэн чухал үүрэгтэй. Нийгмийн хөгжил, дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжилд өндөр мэдлэг боловсролтой, хөрвөх чадвартай, өөрийгөө хөгжүүлэх арга технологийг эзэмшсэн, багшийн ажилдаа дур сонирхолтой, хөгжсөн, жинхэнэ сайн багш үнэтэй хувь нэмрээ оруулна. Иймээс мэдлэгт суурилсан нийгмийг бүтээх, улс эх орны тогтвортой хөгжлийг хангахад хүний нөөцийн чадавхыг оновчтой бүрдүүлэх шаардлагатай. Хувь хүний хөгжлөөс өрх гэрийн хөгжил, улс эх орны хөгжил хамаардаг болсон өнөө үед гол хөдөлгөгч хүч нь болсон багшийн хөгжлийн асуудал боловсролын салбарын тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн болон боловсролын ерөнхий хууль болон дээд боловсролын тухай хуульд тусгасан багшийн хөгжлийн талаарх зорилго, зорилтын хэрэгжилтийг эрчимжүүлэх, нийт багш нарын санал санаачилгыг дэмжих, ажлын байрандаа хөгжих боломжийг судлан бодитой шийдвэрлэх арга замаа хамт олны оролцоонд тулгуурлан тодорхойлж, багшаа тасралтгүй хөгжүүлэх чиглэлд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Ерөнхий зүйл

Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо санхүүжилттэй хөтөлбөрийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбооны хөтөлбөр хариуцлага хүлээхгүй болно. Төслийн ерөнхий зохицуулагчийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
БАГШ БЭЛТГЭХ БОЛОН БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ТОГТОЛЦОО
СУРГАЛТЫН БОДЛОГО, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО

Монгол улсын боловсролын ерөнхий хууль¹-н 7 дугаар зүйлд зааснаар Боловсролын тогтолцоо нь албан, албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцахуйгаас бүрдэх бөгөөд албан боловсрол нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол гэсэн түвшинтэй байна гэж заасан байна.

Боловсролын түвшингээр нь сургуулийн өмнөх боловсрол (2-5 нас) болон бага боловсрол (5 жил), суурь боловсрол (4 жил), бүрэн дунд боловсрол (3 жил), мэргэжлийн болон дээд боловсрол гэж ангилна. Боловсролын ерөнхий хуулийн 3.1.15-д заасан мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц дараах бүтэцтэй байна².

Хүснэгт 1. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц

Түвшин	Албан боловсрол		
	Ерөнхий боловсрол	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалт	Дээд боловсрол
X			Доктор
IX			Магистр
VIII			Бакалавр
VII			Дэд бакалавр/Диплом
VI		Техникийн боловсрол V-VI	
V		Мэргэжлийн боловсрол III-IV	
IV	Бүрэн дунд боловсрол	Мэргэжлийн боловсрол I-II	
III	Суурь боловсрол		
II	Бага боловсрол		
I	Суурь чадамжийн суралцахуй		

Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

¹ Монгол Улсын боловсролын ерөнхий хууль 2023

² Монгол улсын засгийн газрын тогтоол Дугаар 227

БОЛОВСРОЛЫН БҮХ ТҮВШНИЙ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНД АЖИЛЛАЖ БУЙ БАГШИЙН МЭДЭЭЛЭЛ

Сургуулийн өмнөх боловсрол³:

Монгол Улсад 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 1,002; Орон нутгийн өмчийн 22; Хувийн өмчийн 383 нийт 1,407 сургуулийн өмнөх боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрт 9,226 бүлэгт 264,818 хүүхэд сурч, хөгжиж байгаагаас үндсэн сургалтад 253,158; хувилбарт сургалтад 11,660 хүүхэд хамрагдаж байна. Хөгжлийн бэршээлтэй 2150 хүүхэд байна.

Багш: Сургуулийн өмнөх боловсролын 1406 байгууллагад 9945 үндсэн багш; 8,743 туслах багш; 30 гэрээт багш; 208 тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа багш нийт 18926 багш ажиллаж байна. Гэрээт болон тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаагаас бусад багш нарын 86.0 хувь төрийн өмчийн ; 1.7 хувь нь орон нутгийн өмчийн; 12.0 хувь нь хувийн өмчийн сургалтын байгууллагад ажиллаж байгаа юм. Үндсэн багш (9945)-ийн 84.5 хувь нь бүлгийн; 8.5 хувь нь дуу хөгжмийн; 5.7 хувь нь биеийн тамирын; 0.1 хувь нь тусгай мэргэжлийн; 0.6 хувь нь нүүдлийн бүлгийн 0.7 хувь нь явуулын багш тус тус байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 726 багш дутагдалтайгаас бүлгийн багш 164; багшийн туслах 142; хөгжмийн багш 241; биеийн тамирын багш 179 дутагдалтай байна.

Ерөнхий боловсролын сургууль⁴: 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 705; Хувийн өмчийн 180; Засгийн газрын хоорондын гэрээний дагуу байгуулагдсан 2 нийт 887 ерөнхий боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Багш: Ерөнхий боловсролын 887 сургалтын байгууллагад 37770 үндсэн багш ажиллаж байгаагаас төрийн өмчийн сургалтын байгууллагад 32728 багш; хувийн өмчийн сургалтын байгууллагад 5042 багш тус тус ажиллаж байна.

Үндсэн багшийн 12436 нь бага ангийн; 12050 нь зөвхөн дунд ангийн; 5659 нь зөвхөн ахлах ангийн; 7625 нь дунд-ахлах түвшинд ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуульд 1280 багш дутагдалтайгаас бага ангийн 140; мэргэжлийн судлагдахууны 1140 багш дутагдалтай байна.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага⁵:

2024-2025 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсролын сургалтын 70 байгууллага үйл ажиллагаа явуулж буйгаас төрийн өмчийн 41; хувийн 29 байна. Сургалтын байгууллагын хэв шинжээр авч үзвэл, политехник коллеж 39; мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв 28; бусад 3 байна. Сургалтын

³ Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш нарын 2024-2025 оны хичээлийн жилийн тайлан

⁴ Ерөнхий боловсролын сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн тайлан

⁵ Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад ажиллагчдын 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээ

байгууллагын шатлалаар мэргэжлийн боловсролын 69; техникийн боловсролын 41; мэргэжлийн сургалтын 12 байна.

Багш: Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад нийт 2140 үндсэн багш ажиллаж байгаагийн 1700 нь төрийн өмчийн; 440 нь хувийн өмчийн сургуульд ажиллаж байна. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад ерөнхий эрдмийн 90; мэргэжлийн судлагдахууны 91 багш нийт 181 багш дутагдалтай

Дээд боловсролын сургалтын байгууллага⁶:

Дээд боловсролын сургалтын байгууллагаас төрийн өмчийн 16; төрийн өмчийн оролцоотой 1; монгол улсын иргэний 42; гадаадтай хамтарсан 1; гадаад улсын 2; олон нийтийн/шашны 3; гадаадын салбар сургууль 1 байна. Сургалтын байгууллагын ангиллаар их сургууль 34; дээд сургууль 29; коллеж 2; технологийн коллеж 1 байна.

Багш: Дээд боловсролын сургалтын байгууллагын 5151 үндсэн багшаас 3308 нь төрийн өмчийн; 1684 нь хувийн өмчийн; 159 нь олон нийтийн/шашны сургуульд ажиллаж байна. Эдгээр сургалтын байгууллагад 692 цагийн багш ажилладаг. Багшийн албан тушаалын хувьд 5151 үндсэн багшийн 493 профессор; 728 дэд профессор; 1485 ахлах багш; 2083 багш; 362 дадлагажигч багшаар ажилладаг.

Дээд боловсролын сургалтын байгууллага: Дээд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавих шаардлагыг тодорхойлсон бөгөөд... багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх ба семинар, дадлага, лабораторийн хичээлийг тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх, дадлага, туршлагатай мэргэжилтэн удирдаж болно... гэж заасан. Дээд боловсролын сургалтын байгууллага нь багшийг тухайн сургуулийн “Багш сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулж ажиллуулдаг. Одоогоор дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн хомсдолын талаарх нэгдсэн мэдээлэл байхгүй.

БАГШ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ТӨРИЙН ЗОРИЛТУУД, НОГООН БОЛОН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙН ТАЛААР БОДЛОГЫН ЗААЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улс багштай холбоотой тэр дундаа багшийн боловсролтой холбоотой асуудалд анхаарлаа хандуулан бодлогоо тодорхойлж, эрх зүйн нөхцөлөө бүрдүүлэн сайжруулсаар иржээ.

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ...“Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана”... гэжээ. Энэхүү зорилтод хүрэхийн тулд уг бодлогыг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд:

□ “2.1.34. Багшийн стандартыг *мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, мэдээлэл, харилцаа,*

⁶ Дээд боловсролын сургалтын байгууллагын 2024/2025 оны хичээлийн жилийн мэдээ

холбооны технологийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж, багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана”,

- “2.1.44. Багш нарын мэдээлэл, харилцаа, холбооны технологийг сургалтад ашиглах, цахим, зайн сургалт хөтлөх, англи хэлний чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлж, сургалт явуулдаг бүх төрлийн байгууллагын оролцоог хангана” гэж тусгажээ.

Урт хугацааны бодлогын баримт бичгээс гадна Засгийн газраас 2024 онд баталсан “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээ нь 1) багшийг хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх болон 2) багшийн чанарыг сайжруулах гэсэн 2 гол чиглэлээр хэд хэдэн зорилтуудыг дэвшүүлсэн. Тэдгээр зорилтуудаас онцолвол, багш ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд дэмжих, ачааллыг бууруулах чиглэлээр цахим контент, системийг нэвтрүүлэх, багш бүрийг виртуал туслахтай болгох, багшийн мэргэжлийн стандартыг тогтоож, мэргэшлийн зэрэг, мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, багш бэлтгэх хөтөлбөрийн олон улсын стандартын ангилал (ISCED-T)-ыг нэвтрүүлэх зэрэг юм.

Дээрх бодлогын баримт бичгүүдээс үзвэл Монгол Улс нь 1) мэдээлэл, харилцаа, холбооны технологийн мэдлэг, чадвартай; 2) гадаад хэл, тэр дундаа англи хэлний чадвартай; 3) мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны мэдлэг, чадвартай багшийг бэлтгэж, хөгжүүлэхийг чухалчилж байна. Ялангуяа, дижитал шилжилтэд нийцүүлэн багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэхэд илүүтэй анхаарч байна.

Харин ногоон шилжилтийн талаар багштай холбоотой бодлогын баримт бичгүүдэд нарийвчлан тусгаагүй боловч Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030)”-ний Стратегийн зорилт 5.1.2. *“Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн үзэл санааг бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгаж, байгаль хамгаалах уламжлалт ёс заншлаа өвлүүлэх, орчин үеийн амьдралын хэмнэлд нийцсэн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх”* үйл ажиллагааг 2016-2030 онд хэрэгжүүлэхээр тусгажээ. Мөн *“Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”*⁷-ийн 3.1.1. *“суралцагчдад тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг баяжуулж, хэрэгжүүлэх”* гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зорилт тавьсан байна. Эдгээр баримт бичгээс гадна НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго-2030 хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 12.8.1 *“Дэлхийн иргэний боловсрол уур амьсгалын өөрчлөлтийн талаар тусгасан (ii) тогтвортой хөгжлийн боловсролыг а) боловсролын үндэсний бодлого, (b) сургалтын хөтөлбөр, (c) багш нарын боловсрол болон (d) суралцагчийн үнэлгээнд тусгасан байдал”* гэжээ.

⁷ Засгийн газрын 2018 оны 209 дүгээр тогтоол

Дээрх ногоон шилжилттэй холбоотой бодлогын баримт бичгүүдээс үзвэл тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаар сургалтын хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэхээр Монгол Улс зорьжээ. Иймд багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ногоон шилжилтийн талаар хэрхэн туссан болохыг тодорхойлох шаардлага үүсэж байна (Хоёрдугаар бүлгээс үзнэ үү).

БАГШ НАРЫН МЭРГЭШИЛ, ЧАДАМЖИЙН ХҮРЭЭ, ТӨРӨЛ, АНГИЛАЛ

Багшийн цогц чадамж (competency) гэдэг нь багшийн мэдлэг, чадвар, хандлага болон зан үйлийн нэгдэл бөгөөд эдгээрийг тодорхой нөхцөлд багшийн зүгээс ашиглах чадамж гэж ойлгож болох юм (Европын Холбоо (2013), ЭЗХАХБ (2017), Берт Криммерс (2013)). Улс орнуудын туршлагаас үзвэл багшийн цогц чадамжийн хүрээ эсвэл багшийн мэргэжлийн стандарт тогтоож, түүнийхээ дагуу багшийг бэлтгэж, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна (БСҮХ, 2022).

Монгол Улсын тухайд 2022 онд Ерөнхий боловсролын багшийн ажил мэргэжлийн стандартыг баталсан. Хөдөлмөрийн хуулийн 17.6 дахь хэсэгт зааснаар “ажил мэргэжлийн стандарт” гэдэг нь *хөдөлмөрийн нөхцөл, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, ур чадвар, чадамж, хандлага, мэргэшлийн түвшин, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тогтооно*⁸, Боловсролын ерөнхий хуульд “Багш, ажилтан нь боловсролын хууль тогтоомж, Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэжээ. Уг стандартад ерөнхий боловсролын багш нь дараах чадамжтай байхаар тусгажээ.

Хүснэгт 1. Чадамжийн нэгж

Чадамжийн нэгж			
1	Сургалтын хөтөлбөр боловсруулах	7	Хүүхэд хөгжүүлэх
2	Сургалтыг төлөвлөх, загварчлах, зохион байгуулах	8	Хүүхэд хамгаалах
3	Үнэлгээг төлөвлөх, зохион байгуулах	9	Бичиг баримт хөтлөх
4	Гүнзгийрүүлэн судлах хичээлийн хөтөлбөр боловсруулж, зохион байгуулах	10	Байгууллагын хөгжлийн үйл ажиллагаанд оролцох
5	Суралцахуйн үйлийг дэмжих	11	Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуйг мөрдөн ажиллах
6	Анги удирдан ажиллах	12	Багшийн хөдөлмөрийн эрх зүй

Эх сурвалж: ЕБС-ын багшийн ажил мэргэжлийн стандарт, 2022

Эндээс үзвэл Монгол Улсын багшийн мэргэжлийн стандарт нь ажлын байрандаа багшийн хэрэгжүүлэх чиг үүрэгтэй уялдаатай байна. Өөрөөр хэлбэл, мэргэшлийн (professional) стандарт бус, ажил

⁸ Хөдөлмөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг

мэргэжлийн (occupational standard) стандарт гэж тодорхойлж болохоор байна.

Цаашилбал, багшийн цогц чадамжтай холбоотой хэд хэдэн судалгаа Монгол Улсад хийгдсэн байна. Тухайлбал, Багш, бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн судалгаагаар багшийн цогц чадамжийн агуулгын хүрээг тодорхойлжээ (БСҮХ, 2022). Уг хүрээ нь 1) мэргэжлийн мэдлэг, 2) багшлахуй ба суралцахуй, 3) хамтын ажиллагаа, 4) мэргэжлийн хөгжил, үнэт зүйл гэсэн 4 айгаас бүрддэг.

Хүснэгт 2. Багшийн цогц чадамжийн агуулгын бүтэцчилсэн хүрээ

Ай	Чадамжууд
Мэргэжлийн мэдлэг	суралцагчийн талаарх мэдлэг, судлагдахууны мэдлэг, заах арга зүйн мэдлэг, мэдээлэл, харилцаа, холбоо технологийн мэдлэг, боловсролын чиг хандлага, бодлого, эрх зүй, судалгаанд суурилсан мэдлэг,ойлголт
Багшлахуй ба суралцахуй	сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, багшлахуйн ур чадвар, суралцахуйг дэмжих, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж суралцагчийг тэгш хамруулах, үнэлгээ хийх
Хамтын ажиллагаа	эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт, хамт олонтойгоо хамтран ажиллах бусадтай харилцах
Мэргэжлийн хөгжил, үнэт зүйлс	багш өөрийгөө эргэцүүлэхүй, мэргэжлийн тасралтгүй хөгжил, бусад багш нартаа үзүүлэх мэргэжлийн дэмжлэг, багшийн үнэт зүйлс, хандлага

Эх сурвалж: БСҮХ, 2022

БАГШ БЭЛТГЭХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО

Ардын хувьсгалын эхний жилүүдэд багшид тавигдаж байсан шаардлага нь сурах төлөвтэй, чанар сайтай, эрүүл, идэр залуу гэж байсан бол 1940-өөд оны үед элдэв ухааны эрдэм, чанарыг эрхэмлэж, 1950-иад оноос хойш сурган хүмүүжүүлэх дээд боловсролтой багшийг багшлуулах төдийгүй багшийн ргэжлийг тогтмол дээшлүүлэх тухай, 1960-аад оноос хойш сургалтыг амьдрал практиктай холбох багшийн бүтээлч санаачилгыг дэмжих, 1990-өөд оноос хойш багшийн ёс зүй, мэргэжлийн чадварыг эрхэмлэсэн бодлогыг тухай бүр хэрэгжүүлсээр иржээ.⁹

⁹ Монголын багш боловсролын талаарх бодлогын өөрчлөлтийн судалгаа, 2018 Б.Жадамба, Чү.Байгалмаа, МУБИС <https://lavai.msue.edu.mn/ppapers/20-LAV-001.pdf>

- 1921-1924 он Засгийн газрын шийдвэрээр Бичиг үсгийн багшийг 4 сарын курсээр бэлтгэж эхэлсэн.
- 1924-1940 он Засгийн газрын шийдвэрээр Багш нарыг бэлтгэх сургуулийг байгуулж 3 жилийн багш бэлтгэх болсон.
- 1924-1960 он Дээд боловсролтой багш бэлтгэх болсон
- 1960-1991 он Багшийг дээд тусгай мэргэжлийн дунд сургуулиар бэлтгэх
- 1991 оноос хойш ЕБС-н багшийг их сургууль, коллежоор; Мэргэжлийн сургуулийн багшийг Монгол Улсын их сургуулиар; ИДС-н багшийг ШУ өндөр хөгжсөн оронд бэлдэх (1991) ЕБС-д бакалавр; ИДС, коллежид магистраас доошгүй багш багшлах
- 2023 он. Боловсролын ерөнхий хууль¹⁰-н 12 зүйлд багш бэлтгэх тухай заасан байна. Тухайлбал,
 - ▣ 12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.
 - ▣ 12.5.Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр багшийг бэлтгэнэ. Багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшаар ажиллаж болно.
 - ▣ 12.7.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ.
 - ▣ 12.8.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.
 - ▣ 12.9.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.8-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно.
 - ▣ 12.10.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.
 - ▣ 12.16.Багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангийн суралцагчийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн сул орон тоонд Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

Багшийн эрэлт хэрэгцээ : Боловсролын салбарын хэтийн тооцоо 2020-2050 судалгаанаас үзэхэд¹¹ Сургуулийн өмнөх боловсролын багшийн хэрэгцээ: нормативын хувьд 2025 онд 12.9 мянга; 2035 онд 12.8 мянга; 2045 онд 16.0 мянга; 2050 онд 16.7 мянга болох төлөвтэй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хэрэгцээ: нормативын хувьд 2025 онд 24,0 мянга; 2035 онд 26.4 мянга; 2045 онд 29.1 мянга; 2050 онд 30.6 мянга болох төлөвтэй байна.

¹⁰ Монгол Улсын боловсролын ерөнхий хууль 2023

¹¹ Боловсролын салбарын хэтийн тооцоо 2020-2050 Үндэсний статистикийн хороо, БШУЯ 2022

Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан¹²-аас үзэхэд 2030 он гэхэд нийт 31284 багшийг шинээр бэлтгэн ЕБС-ууд руу нийлүүлэх шаардлагатай байна. (Хүснэгт 4.)

Хүснэгт 3. Багшийн эрэлт хэрэгцээ

Хичээл	2018			2020		2025		2030	
	Одоо	Нийт	Шинэ	Нийт	Шинэ	Нийт	Шинэ	Нийт	Шинэ
Бага ангийн багш	10397	10759	362	11727	1590	12265	3428	12696	5158
Судлагдахууны багш	19541	23563	4022	26628	7575	36761	20149	40294	26126
Нийт багш	29940	34323	4383	38355	9163	49025	23576	53082	31284

БАГШ БЭЛТГЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Мэргэжлийн боловсролд: Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 сарын 11-өдрийн “Мэргэжлийн болон Техникийн боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн индекс чиглэл батлах тухай” А/11дүгээр тушаал батлагдсан. Тушаалаар 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн Багш, сургуулийн өмнөх боловсрол (011201индекс) нарийвчилсан чиглэл, сургуулийн өмнөх боловсролын багшийн туслахыг мэргэжлийн боловсролын III-IV түвшинд бэлтгэх; Багш мэргэжлийн чиглэлээр (011441 индекс) мэргэжлийн сургалтын дадлагажуулагчийг мэргэжлийн сургалтын I-IV түвшинд бэлтгэхээр баталсан байна.

Дээд боловсролд: Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 сарын 09-ны өдрийн мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай А/160 дүгээр тушаал, 2024 онд А/146 дугаар тушаал батлагдсан. Бакалаврын түвшинд 2024-2025 оны хичээлийн жилд нийт 27 индексээр багшийг бэлтгэж байна. (Хүснэгт 5.)

Хүснэгт 4. Багш мэргэжлээр төгсөгчдийн тоо 2023-2024 оны байдлаар¹³

Д/Д	Нарийвчилсан чиглэл	Бакалаврын боловсрол	Эрэгтэй	Эмэгтэй
Бакалавр Бүгд		20,906	7,500	13,406
1	Багш, сургуулийн өмнөх насны боловсрол	421	4	417
2	Багш, сургуулийн өмнөх боловсрол	291	16	275
3	Багш, бага ангийн боловсрол	392	12	380
4	Багш, бага боловсрол	141	7	134

¹² Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан, 2019. БСШУСЯ, АХБанк

¹³ Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн 2023/ 2024 оны хичээлийн жилийн мэдээ,

5	Багш, математикийн боловсрол	109	23	86
6	Багш, байгалийн ухааны боловсрол	93	14	79
7	Багш, нийгмийн ухааны боловсрол	186	31	155
8	Багш, мэдээлэл зүйн боловсрол	13	5	8
9	Багш, урлагийн боловсрол	212	68	144
10	Багш, насан туршийн боловсрол	5	1	4
11	Багш, тусгай хэрэгцээт боловсрол	16	1	15
12	Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	170	8	162
13	Багш, биологийн боловсрол	1	0	1
14	Багш, гадаад хэлний боловсрол	274	31	243
15	Багш, биеийн тамирын боловсрол	275	199	76
16	Багш, эрүүл мэндийн боловсрол	7	0	7
17	Багш, нийгмийн ухааны боловсрол	4	0	4
18	Багш, дүрслэх урлагийн боловсрол	5	5	0
19	Багш, дизайн технологийн боловсрол	6	1	5
20	Багш, хөгжмийн боловсрол	20	6	14
21	Багш, бүжгийн боловсрол	9	4	5
22	Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол	13	0	13
23	Багш, гадаад хэлний боловсрол	95	25	70
24	Багш, биеийн тамирын боловсрол	58	47	11
25	Багш, мэргэжлийн боловсрол сургалт	0	0	0
Багш мэргэжлээр төгсөгчид		2816	508	2308

БАГШ НАРЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ҮНЭЛГЭЭ, АТТЕСТАТЧИЛАЛ, ТҮҮНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Багшийн сонгон шалгаруулалтад тавих шаардлага: Багшлахуйн кластерт багшийг ажилд сонгон шалгаруулах нь олон хүчин зүйлээр тодорхойлогддог.

- 2019 оноос мөрдөгдөж эхэлсэн Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д ...Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна... , 2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д ...Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна... гэж тус тус заасан байна.

Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчин:

Төрийн албаны тухай хууль болон 2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хууль болон дагалдах хуулиудад багшийн үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаанууд, эрх мэдэлтэй холбоотой хууль эрх зүйн суурь харилцаанууд зохицуулагдсан байдаг. Тухайлбал:

- Боловсролын ерөнхий хуульд багшийн эрхийг 8, багшийн үүргийг 18, нийгмийн баталгааг 12
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд багшийн ажил үүргийг 10
- Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд багшийн эрхийг 7, багшийн үүргийг 6, нийгмийн баталгааг 3
- Дээд боловсролын тухай хуульд багшийн эрхийг 4, багшийн үүргийг 3, нийгмийн баталгааг 6 заалтаар тус тус тусгаж, зохицуулсан байна.

2018-2020 онд шинээр боловсруулагдан хэрэгжиж буй “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Чадварлаг багш” хөтөлбөр төлөвлөгөө, 2023 онд шинэчлэн батлагдсан Боловсролын ерөнхий хууль болон дагалдах хуулиудад багш мэргэжлээр ажиллах, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоог шинэчлэн сайжруулахад чиглэсэн байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд багш сонгон шалгаруулахдаа Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага, Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтыг үндэслэн боловсруулсан дотоод журмыг баримталж байна

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн:

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарт 2022, 2023 онд байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулж, ахиц, үр дүнг тооцож, нийтэд зарлаж эхэлсэн бөгөөд багшийн ажлыг

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүн;
- Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны ахиц, үр дүн;
- Багшийн мэргэжлийн ахиц, үр дүн;
- Байгууллага, олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, үр дүн гэсэн 4 үндсэн шалгуураар үнэлж байна.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн:

- 2023 онд 6513 багш хамрагдсан бөгөөд I түвшинд 406, II түвшинд 790, III түвшинд 801, IV түвшинд 1267, V түвшинд 3249 багш үнэлэгдсэн байна.
- 2024 онд 7,036 багш хамрагдсан бөгөөд I түвшинд 510, II түвшинд 938, III түвшинд 911, IV түвшинд 1424, V түвшинд 3253 багш үнэлэгдсэн .

2024 оны гүйцэтгэлийн үнэлгээг өмнөх онтой харьцуулахад I түвшинд 104, II түвшинд 148, III түвшинд 110, IV түвшинд 157, V түвшинд 4 багш тус бүр түвшнээ ахиулсан байна.

Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн:

- 2023 онд 28006 багш хамрагдсан бөгөөд I түвшинд 893, II түвшинд 3338, III түвшинд 3207, IV

түвшинд 4768, V түвшинд 15800 багш тус тус үнэлэгдсэн.

- 2024 онд 28743 багш хамрагдсан бөгөөд өмнөх оны үнэлгээнд хамрагдсан багшаас 737 багш ахисан байна. Мөн I түвшинд 1874, II түвшинд 5481, III түвшинд 4604, IV түвшинд 4419, V түвшинд 12365 багш хамрагдсан.

2024 оны гүйцэтгэлийн үнэлгээг өмнөх онтой харьцуулахад I түвшинд 981, II түвшинд 2143, III түвшинд 1397, IV түвшинд 349, V түвшинд 3435 багш тус бүр түвшнээ ахиулсан байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын салбар-ын хувьд 2025 оны 2 дугаар сараас оноос байгууллага болон багшийн гүйцэтгэлийг үнэлэх ажлыг эхлүүлж байгаа бөгөөд 2025 оны 2 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд төрийн өмчийн 31 сургалтын байгууллагад гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулж, цаашид 3 дугаар сараас багшийн гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахаар төлөвлөсөн нь тухайн салбарт байгууллагын болон багшийн гүйцэтгэлийг үнэлэх ажлын суурь тавигдсаныг харуулж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн үнэлгээ:

Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн ажлын нэгдсэн үнэлгээг боловсролын эрх зүйн баримт бичигт үндэслэн их, дээд сургууль дотоор журмаар зохицуулдаг бөгөөд үнэлгээний агуулгын 40 хувийг сургалт заах арга зүй; 30 хувийг эрдэм шинжилгээний ажил; 15 хувийг мэргэжлийн үйлчилгээ; 15 хувийг нийгмийн үйлчилгээ эзэлдэг байна. Багшийн нэгдсэн үнэлгээ аттестатчиллын дүнг багтай холбоотой цалин урамшуулал олгох болон хасах; албан тушаалын зэрэглэл тогтоох; хөдөлмөрийн гэрээ сунгах цуцлах гэх мэт асуудлыг шийдвэрлэхэд ашигладаг.

БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ТАСРАЛТГҮЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ АЛБАН БА АЛБАН БУС СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО

Бүх түвшний багшийн мэргэжлийн тасралтгүй өсөлт хөгжлийг хангах сургалтын тогтолцоо нь 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль болон 2023 онд шинэчлэн батлагдсан Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулиудын хүрээнд зохицуулагдаж байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын багш: Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.11-т “Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд тухайн түвшний боловсролын сургалтын байгууллага болон багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн боловсролын харилцаанд оролцогч талуудтай хамтран зохион байгуулна”, 12.12-т “Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна” гэж тус тус заасан байна.

Мөн 13 дугаар зүйлийн 13.17-д “цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах” гэж заасны дагуу хэрэгжилтийг хангах хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилд гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн багш нарын хэрэгцээнд тулгуурласан 154 модуль сургалтын агуулгыг 128 багийн 374 эрдэмтэн, судлаач, багш нараар

боловсруулан СӨБ, ЕБС-ийн 37902 багш, ажилтныг цахим сургалтад хамруулж, мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн байна. Сургалтад оролцогчдын дундаж гүйцэтгэл 90.5 хувьтай байв.

СӨБ, ЕБС-ийн багш, ажилтнууд хөгжих хэрэгцээндээ тулгуурласан багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих цахим платформд суурилсан модуль сургалтуудад хамрагдахын зэрэгцээ Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т заасны дагуу Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулах “багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх” сургалтад хамрагдаж, мэргэжил, арга зүйгээ тасралтгүй дээшлүүлэх боломжтой.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын багш: Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24 дүгээр зүйл (Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг)-ийн 24.1.4-т “багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншлэгч талтай хамтран зохион байгуулах” -аар, мөн хуулийн 29 дүгээр зүйлд заасан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг “багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт, мэргэшүүлэх сургалтын зардал” -ын зориулалтаар зарцуулж болохоор зохицуулсан байна.

2023-2024 оны хичээлийн жилд 76 мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад 2252 багш ажиллаж байгаа бөгөөд 2023, 2024 онуудад багшлах эрх, чадамжийн үнэлгээ, арга зүйн чиглэлийн 5 удаагийн сургалтад нийт 1550 багш хамрагдсан нь нийт багш нарын 68.6 хувийг эзэлж байна.

Дээд боловсролын багш: Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн тасралтгүй өсөлт хөгжлийг хангах тогтолцоо нь 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль болон 2023 онд шинэчлэн батлагдсан Дээд боловсролын тухай хуулиар зохицуулагдаж байна. Энэ хүрээнд 2020-2021 онд их, дээд сургуулийн багш нарын судалгаа, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага хуваалцах боломжийг бий болгох зорилгоор 9 удаагийн “Science” цахим хэлэлцүүлэг зохион байгуулж төрийн болон төрийн бус өмчийн 80 их дээд сургуулийн 3187 багшийг хамруулсан бол профессор багш нарын мэргэшлийн ур чадварт дэмжлэг үзүүлэх 7 удаагийн цахим сургалт зохион байгуулж 51 их дээд сургуулийн 1670 гаруй багшийг тус тус хамруулсан байна. Үүний дүнд 1 жил гаруйн хугацаанд их, дээд сургуулийн нийт 7143 багшийн 67.9 хувьд хүрч чаджээ.

2023 онд шинэчлэн батлагдсан Дээд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д “... Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ...” гэж заасны дагуу 2024-2025 оны хичээлийн жилд сургалт, үйл ажиллагаа явуулж буй 61 дээд боловсролын сургалтын байгууллага тус бүр багшийн хөгжлийг хангах журмын хүрээнд багшийн хөгжлийн төв, баг, багшийн хөгжил хариуцсан

мэргэжилтэн, багш нараараа дамжуулан сургалтын байгууллагынхаа багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах сургалт, үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна.

Их дээд сургуулиудын багшийн тасралтгүй хөгжлийн дэмжих ажил нь багшийн хөгжлийн төв, баг, багш хариуцан багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа бөгөөд 61 их, дээд сургуулийн 80 гаран хувь нь багшийн хөгжлийн тусдаа төвтэй, 20 орчим хувь нь багшийн хөгжлийн хамтарсан баг ажиллах эсвэл өөр нэгжийн чиг үүргийн хүрээнд хамааран сургалт, үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

НҮБ-аас дэвшүүлсэн 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр БМДИ-ээс ЕБС, СӨБ-ын багш, ажилтнуудад Тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, агуулга, арга зүйг таниулах сургалт зохион байгуулах, арга зүйн модуль, зөвлөмж боловсруулах, дотоодын хүний нөөцийг чадавхжуулах, үндсэн сургалтын хөтөлбөрт ТХ, ТХБ-ын үзэл санаа, агуулгыг интеграцчилах зэргээр “Тогтвортой хөгжлийн боловсрол” төсөлтэй 2014 оноос эхлэн хамтран ажилласан байна. 2013-2024 онд эхний болон 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш, удирдах болон бусад ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт ТХ, ТХБ-ын чиглэлээр зорилтот бүлэг тус бүрийн хөтөлбөрт 4-6 цагийн агуулгыг тогтмол тусган хэрэгжүүлжээ. Үүний үр дүнд ТХ, ТХБ-ын агуулгыг мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтаар дамжуулан СӨБ, ЕБС-ийн нийт багш, /захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, номын санч, эмч/ удирдах болон сургалтыг дэмжих чиг үүрэг бүхий ажилтнуудын 66 хувь нь тодорхой хэмжээгээр судалсан байна.

2021 онд “Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Дэлхийн том хичээл-ТХБ” үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн багш нараас нийт 411 хичээл ирүүлсэн бөгөөд тусгай шалгуурын дагуу үнэлсэн 110 шилдэг арга зүй, туршлага бүхий хичээлийг esd.mn цахим сайтад байршуулан олон нийтэд хүргэсэн байна.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА БАГШИЙН ЧАДАМЖИЙН УЯЛДАА

Монголын боловсролын тунхаглал 2024-д:

- Монголын боловсролын алсын харааг ...Хүн төрөлхтний нийтлэг соёлыг хүндэтгэх, ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлоох, гэр бүлийн амьдралын баталгаа болох, хувь хүний хөгжлийг дэмжих, монгол хүнийг төлөвшүүлэх гэж тодорхойлсон бөгөөд мэдээлэл технологийн дэвшилд тулгуурлан боловсролын үр ашгийг дээшлүүлнэ... хэмээжээ.
- Монголын боловсролын тогтолцоо нь суралцагч төвтэй байх бөгөөд Монгол суралцагчийн дүр төрхийг Хүн төрөлхтний соёлыг хүндэтгэдэг, дэлхийн соёлоос суралцдаг “дэлхийн хүн”; үндэсний соёл, уламжлал, ёс заншлаа өвлөн хөгжүүлдэг “соёлыг уламжлагч”; ардчилсан, хүмүүнлэг, иргэний нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулдаг “хүнлэг иргэн”; нийгмийн болон гэр бүлийн

”хариуцлагатай гишүүн”; бие дааж, насан туршдаа суралцдаг ”тасралтгүй суралцагч” байна гэж тодорхойлсон байна.

- Монгол суралцагчийн дүр төрх нь чадамжаар тодорхойлогдох бөгөөд чадамжийг боловсролын түвшин бүрд залгамж холбоотойгоор хөгжүүлэхээр тусгажээ.
- Монголын боловсролын хувирган өөрчлөлтийг эрчимжүүлэхэд цахим технологийг тууштай ашиглах; цахимаар, их өгөгдөлд тулгуурласан суралцахуйг дэмжих олон талт үйл ажиллагааг дэмжих; ес зүйтэй ажиллах тухай тусгажээ.

Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үндэслэл: эрх зүй, бодлого:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” батлагджээ. Уг үзэл баримтлал нь “суралцагчийн эзэмших чадамжийг тодорхойлж, эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр, судлагдахууны хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, арга зүй, үнэлгээний нийцтэй байдлыг харгалзан боловсруулах үйл ажиллагааг чиглүүлэх” зорилготой бөгөөд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад баримтлах суурь баримт бичиг юм. Хүснэгт -д сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, багшийн чадамжийн хүрээ болон ажил мэргэжлийн стандартад туссан чадамжуудтай харьцуулсан үр дүнг харуулав. Харьцуулалтын үр дүн нь багшийн цогц чадамжийн хүрээ болон үзэл баримтлалд туссан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах багшийн чадамж хоорондоо уялдаж байгааг харуулж байна.

“Монгол суралцагчийн эзэмших чадамж”-ийг суурь болон ерөнхий чадамжаас бүрдэхээр үзэл баримтлалд тодорхойлж өгсөн байна.

Суурь чадамж	Ерөнхий чадамж
Эх хэл, бичиг үсэг	Бүтээлчээр, шүүн тунгаах сэтгэлгээ
Математик	Суралцах арга барил
Шинжлэх ухаан (байгалийн ба нийгмийн)	Харилцаа, хамтын ажиллагаа
Компьютерын ухаан ба цахим технологи	Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил
Англи хэл болон бусад гадаад хэл	Тогтвортой хөгжил
Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал	Үндэсний болон дэлхийн өв соёл

Хүснэгт.... . Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал болон багшийн чадамжийн уялдааг харьцуулсан үр дүн

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал	Багшийн цогц чадамжийн хүрээ	ЕБС-ийн багшийн ажил мэргэжлийн стандарт
---	------------------------------	--

4.1. Сургалтын төлөвлөгөө, хугацаа	Багшлахуй ба суралцахуй · сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах,	1. Сургалтын хөтөлбөр боловсруулах 2. Сургалтыг төлөвлөх, загварчлах, зохион байгуулах 4. Гүнзгийрүүлэн судлах хичээлийн хөтөлбөр боловсруулж, зохион байгуулах
4.2. Суралцахуйн онол, арга хэлбэр Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн суралцахуйн загварын, бодит суралцахуйн, конструктивист болон хувилбарт сургалтын онолын үндсэн дээр боловсруулсан сургалтын идэвхтэй аргыг хэрэглэнэ. Идэвхтэй сургалтын арга зүйг танхимын болон танхимын бус, холимог сургалтад цахим технологитой хослуулан хэрэглэнэ.	Мэргэжлийн мэдлэг · суралцагчийн талаарх мэдлэг, · заах арга зүйн мэдлэг Багшлахуй ба суралцахуй · багшлахуйн ур чадвар, · суралцахуйг дэмжих Мэргэжлийн мэдлэг · мэдээлэл, харилцаа, холбоо технологийн мэдлэг	7. Хүүхэд хөгжүүлэх
4.3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд цахим технологийг ашиглахад баримтлах чиглэл Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд суралцагчийн унших, үзэх, сонсох идэвхтэй үйлийг дэмжсэн, бие даан ажиллах боломжтой цахим хэрэглэгдэхүүн, сургалтын нээлттэй материал, интерактив контент, платформыг ашиглана.	Мэргэжлийн мэдлэг · мэдээлэл, харилцаа, холбоо технологийн мэдлэг	
4.4. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, дэд бүтэц	Багшлахуй ба суралцахуй · багшлахуйн ур чадвар, · суралцахуйг дэмжих · ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж суралцагчийг тэгш хамруулах	8. Хүүхэд хамгаалах
4.5. Суралцагчийн үнэлгээ	Багшлахуй ба суралцахуй · үнэлгээ хийх	3. Үнэлгээг төлөвлөх, зохион байгуулах

4.6. Сургалтаас гадуурх үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талууд Сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон төр, төрийн бус байгууллага, олон нийтийн түншлэлийг эрхэмлэнэ.	Хамтран ажиллах · эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт, хамт олонтойгоо хамтран ажиллах · бусадтай харилцах	6. Анги удирдан ажиллах 7. Байгууллагын хөгжлийн үйл ажиллагаанд оролцох
--	--	---

ДҮГНЭЛТ

1. Сургуулийн өмнөх боловсролоос мэргэжлийн боловсролын түвшинд судлагдахууны болон мэргэжлийн багшийн дутагдал байсаар байна. Багшийн дутагдлыг нөхөх, багшийн эрэлтийг өгөгдөлд тулгуурлан судалж тоон мэдээллийг гаргасан байна.
2. Бүх шатны боловсролын байгууллагад ажиллах багшлах боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд мэргэжлийн багшийн хангалтыг 100%-д хүргэх, гарааны багшийн стандартыг хангасан багш мэргэжлээр төгсөгчдийг 70%-д хүргэхээр “Багшийн гурван тулгуурт бодлого”-д заасан. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлтийг эрчимжүүлэхэд багш боловсролын талаарх төрийн зорилтууд чиглэж байгаа ч ногоон болон дижитал шилжилтийн талаар багшийн бодлогод тусаж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанууд дутмаг байна.
3. Цахим (дигитал) шилжилттэй холбоотой зорилтууд урт хугацааны болоод багшийн талаарх бодлогод илүүтэй тусгагдаж хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч багш нарын мэдээлэл, харилцаа, холбооны технологийн чадвар сайжруулах шаардлагатай чадварт орсон хэвээр байна (БСҮХ, 2022).
4. Төрөөс багшийн талаар баримтлах нэгдсэн бодлого боловсролын аль ч түвшинд төдийлөн тодорхойлогдоогүй тул өөр хоорондоо зөрүүтэй мэргэшил, чадамжийн хүрээ, тэдгээрийн төрөл ангилал боловсруулагдах, багш мэргэжлийн нэгдмэл байдал алдагдах эрсдэлтэй юм.
5. Багшийн боловсролын бодлогыг сайжруулахын тулд онолын болон арга зүйн үндэс суурийг тодорхойлсон ойлголтын цогц хүрээ шаардлагатай бөгөөд багш бэлтгэх хөтөлбөрт мөрдөх үндэсний түвшний нэгдсэн стандарттай сургалтын хөтөлбөр боловсруулах хэрэгцээ бий. Энэ хүрээнд боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний холбогдох хэсгүүдийг нягтлан шалгаж, багшийн боловсролын бодлогыг сайжруулахад чиглэсэн санал болгож буй хөтөлбөрүүдийг судлах шаардлагатай байна. Иймд ирээдүйн багш нарт чанартай, жигд сургалтыг хангахын зэрэгцээ одоогийн багш нарын мэргэжлийн хөгжил, ажлын байраар хангах асуудалд Засгийн газраас чиглэсэн, үр дүнтэй арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй. Мөн багш нарыг “мэдлэг түгээгч” хэмээн үзэх дэлхий нийтийн чиг хандлагыг хүлээн зөвшөөрч, бодлого боловсруулах үйл

явцад багш нарыг өргөн хүрээнд оролцуулах, тэдний үзэл бодлыг тусгах нь нэн чухал юм. 2022 онд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан “Боловсролыг өөрчлөн шинэчлэх үндэсний хэлэлцүүлэг”-ийн үеэр авьяастай, чадвартай сурлагчдыг багшийн мэргэжлээр бэлтгэхэд чиглэсэн бодлого боловсруулах, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь багш бэлтгэлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой болохыг онцолсон. Иймд энэхүү асуудлыг багшийн боловсролын стратеги боловсруулах явцад орхигдуулахгүй байх нь зүйтэй юм.

6. Монгол Улсад боловсролын бүх түвшинд багшийг ажилд авах, ажиллуулах, үнэлгээ, аттестатчилалд оруулах зэрэг үйл ажиллагаа нь Төрийн албаны тухай хууль болон 2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хууль болон дагалдах хуулиуд, холбогдох хэм хэмжээний актуудын хүрээнд зохицуулагдахын зэрэгцээ ажлын үнэлгээ, үнэлгээний шалгуур, үзүүлэлтийн хувьд боловсролын түвшин, тухайн сургалтын байгууллагын онцлогоос хамаарч байна. Тухайлбал, СӨБ, ЕБС-ийн багшийн ажлыг 2022 оноос эхлэн 3 жил дараалан зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр хөндлөнгөөс үнэлж хэвшсэн бол Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд нийтлэг журмын хүрээнд байгууллага бүр онцлог байдлаар багшийн ажлаа үнэлэн шаардлагатай сургалт, үйл ажиллагаанд хамруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, урамшуулал олгох боломж бүрдсэн байна.

Багшийн үнэлгээ, аттестатчилал, шалгуур үзүүлэлтүүдийг багшийн мэргэжлийн стандарттай уялдуулах, ахиж дэвших карьерын өсөлттэй нь хамааруулан холбох зохицуулалт хийвэл зохимжтой юм.

7. Боловсролын яамны зүгээс Багшийн мэргэжлийг дэмжих үндэсний төвийг МУБИС-ийн дэргэд Кембрижийн боловсролын түншлэл (КБТ) байгууллагатай хамтран 2024 онд байгуулсан. Тус төвд ажиллах сурлагч багш нарыг чадавхжуулах сургалтуудыг мөн КБТ байгууллагатай хамтран зохион байгуулж байна. Ингэснээр багш бэлтгэх болон багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах албан сургалтын тогтолцооны эхлэл тавигдаж байгаа юм. Багшийн мэргэжлийг дэмжих үндэсний төв нь бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн тасралтгүй өсөлтийг хангах, багшийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх хэмжээнд нөөц чадавхаа бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.
8. Засгийн газраас 2024 онд сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг баталсан. Уг үзэл баримтлалд цаашид батлагдан хэрэгжих сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга зам нь олон улсын туршлагатай нийцсэн байна хэсээн бөгөөд Монгол Улс өнөөдрийн байдлаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр сурах бичгийг шинэчлэн боловсруулж эхлээд байна. Иймд багшийн чадамжийн хүрээг уг үзэл баримтлалд нийцүүлэхэд мөн анхаарах шаардлагатай байна.

Ашигласан материал,эх сурвалж

1. Монгол Улсын боловсролын ерөнхий хууль УИХ, 2023
2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль. УИХ, 2023
3. Монгол Улсын Хөдөлмөрийн тухайн хууль,
4. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль. УИХ, 2018
5. Монгол улсын засгийн газрын тогтоол дугаар 227 “Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц батлах тухай”,2024
6. Монгол улсын засгийн газрын тогтоол дугаар 192"Багшийн гурван тулгуурт бодлого" цогц арга хэмжээг батлах тухай”, 2024
7. Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024оны 03 сарын 20өдөр А/146 дүгээр тушаал
8. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш нарын 2024-2025 оны хичээлийн жилийн тайлан
9. Ерөнхий боловсролын сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилийн тайлан
10. Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад ажиллагчдын 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээ
11. Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн 2023/ 2024 оны хичээлийн жилийн мэдээ
12. Дээд боловсролын сургалтын байгууллагын 2024/2025 оны хичээлийн жилийн мэдээ
13. Боловсролын салбарын хэтийн тооцоо 2020-2050 Үндэсний статистикийн хороо, БШУЯ,2022.
14. Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан, БСШУСЯ, АХБанк,2019.
15. Дээд боловсролын багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургалт, үйл ажиллагааны тайлан. БМДИ, 2022
16. Б.Жадамба,Чү.Байгалмаа, Монголын багш боловсролын талаарх бодлогын өөрчлөлтийн судалгаа, 2018 МУБИС <https://lavai.msue.edu.mn/ppapers/20-LAV-001.pdf>
17. Багшийн хөгжих хэрэгцээнд тулгуурласан модуль сургалтын тайлан. БЕГ. 2023
18. Багшийн хөгжих хэрэгцээнд тулгуурласан модуль сургалтын тайлан. БЕГ.2024

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАГШ МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

НЭГ. УДИРТГАЛ

1.1 Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж нийгмийн хөгжлийн стратегийг илүү иргэн төвтэй байхаар тодорхойлсон юм. Тус бодлогын баримт бичгийн 2.1-т Засгийн газраас хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ гэж заажээ (УИХ, 2020b). Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрөөс боловсролын салбар дахь хүний нөөцийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, мэргэжлийн хөгжлийн тогтолцоог бүрдүүлж мерит буюу чадахуйн зарчимд үндэслэн боловсон хүчний сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, салбарын хүрээнд жендерийн тэгш байдлыг хангах, хөдөө орон нутаг болон алслагдсан бүсийн боловсролын салбарын албан хаагчдыг орон сууцаар хангах зэрэг нэлээд чухал арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улсад багшаар ажиллахад их, дээд сургуульд суралцаж багшийн мэргэжил эзэмшсэн байх шаардлага тавьдаг. Харин шинээр батлагдсан Боловсролын ерөнхий хуульд зааснаар багшаас өөр мэргэжил эзэмшсэн Монгол Улсын иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшийн мэргэжлээр ажиллах боломжтой болсон билээ (УИХ, 2023). Улсын хэмжээнд нийт 859 сургуульд эдгээр ерөнхий боловсролын сургуулийн багш нар ажиллаж байгаа бөгөөд ойролцоогоор 4 сургууль тутмын нэг (23.1%) нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг гэсэн тоон мэдээлэл бий (БШУЯ, 2023в).

Монгол улсын нийт хүн ам 3.504.741-д хүрсэн (ҮСГ, 2023) ба нийт хүн амын 1/3 нь буюу 1.195.600 хүн аль нэг шатны боловсролын байгууллагад суралцаж, боловсрол эзэмшиж байна. Харин 2024-2025 оны хичээлийн жилд 65 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 34 буюу 52.3 хувь нь их сургууль, 29 буюу 44.6 хувь нь дээд сургууль, 2 буюу 3.1 хувь нь коллеж байна. Нийт их, дээд сургууль, коллежийн 16 нь төрийн өмчийн, 42 нь хувийн өмчийн, 3 нь олон нийтийн/шашны өмчийн сургалтын байгууллага байна. Түүнчлэн их, дээд сургууль, коллежид нийт 150.282 суралцагч суралцаж байна. Нийт суралцагчдын 81.571 буюу 54.3 хувь нь төрийн өмчийн, 60.111 буюу 40.0 хувь нь хувийн өмчийн, 8.600 буюу 5.7 хувь нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна.

Харин Монгол Улсын хэмжээнд багш 32 их, дээд сургууль “багш” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд 16 их, дээд сургууль багш мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж,

төгсөлт хийжээ. 2024-2025 оны хичээлийн жилд багш боловсролоор нийт 14773 суралцагч (багш, сургуулийн өмнөх боловсрол – 3163, багш, бага боловсрол – 2684, багш, мэргэжлийн - 8926) суралцаж байгаагаас бакалаврын түвшинд 13971 оюутан суралцаж байна.

2023 онд “Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг МУБИС-ийн захирлын А/188 тоот тушаалаар баталсан бол 2024 онд А/349 тоот тушаалаар “Гарааны багшийн стандарт”-ыг тус тус батлан гаргасан нь МУБИС-с бэлтгэгдэн гарч буй багшийн чадамжийн хүрээг тогтоосон. (Хавсралт 1, 2). Түүнчлэн МУБИС-ийн хувьд Багш, Насан туршийн боловсрол бакалавр болон магистрын хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь Монгол улсын хэмжээнд тодорхой шалтгааны улмаас ерөнхий боловсрол эзэмшиж чадаагүй хүүхэд, залуучууд болон бусад иргэдэд боловсрол нөхөн олгох хөтөлбөрийг хэрэгжүүлдгээрээ онцлогтой. (Хавсралт 3)

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд боловсролын салбарт тавигдаж буй стратегийн зорилтуудын нэг нь “хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангах, насан туршийн боловсролын тогтолцоог хувь хүний хөгжил, гэр бүлийн сайн сайхан байдал, үндэсний хөгжлийн суурь болгон бэхжүүлэх” явдал юм.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Боловсролын тухай хуулийн 17.3 дугаар зүйлд “Насан туршийн болон албан бус боловсролын төвүүд нь бүх шатны удирдлагын түвшинд насан туршийн болон албан бус боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд бие даан болон боловсролын байгууллагатай хамтран ажиллаж болно” гэж заасан байдаг.

2021 онд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас “Ерөнхий боловсролын бага, суурь болон бүрэн дунд боловсрол нөхөн олгох хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөр нь боловсролоос гадуур орхигдсон хүүхэд, залуусын тэгш боловсрол эзэмших боломжийг дэмжих журмыг тодорхойлсон бөгөөд сургалтын хэлбэрүүдийг суралцагчийн нөхцөл байдалд нийцүүлэн ангид, зайнаас, гэрээр, бие даан болон хосолмол хэлбэрээр зохион байгуулдаг.

Гэсэн хэдий ч доорх 1-р хүснэгтэд тусгагдсан өнөөгийн хэрэгжилтийн үнэлгээнээс харахад, энэхүү хөтөлбөрт байгаль орчны тогтвортой хөгжилтэй холбоотой “ногоон боловсролын” зарчмууд хангалттай тусгагдаагүй байна. Цахим хэлбэрийн сургалт (жишээлбэл, зайны болон мэдээлэл, технологид суурилсан сургалт) нэмэгдэж байгаа нь боловсролын цахим шилжилтийн хүрээнд ахицтай боловч, сургалтын хөтөлбөр нь байгальд ээлтэй амьдралын хэв маяг, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, тогтвортой хөгжлийн зорилгууд (SDGs)-тай уялдсан байдал сул байна.

Ногоон боловсролын тогтолцоонд шилжих шилжилтийг дэмжихийн тулд дараах зүйлсийг үнэлэх шаардлагатай:

- Нөхөн олгох болон насан туршийн боловсролын хөтөлбөрүүд байгаль орчны сэдвийг хэрхэн ^統 хангаж байгааг;
- Багш бэлтгэл болон давтан сургалтад “ногоон боловсролын” чадамжууд багтсан эсэхийг;
- Сургалтын арга зүй нь тогтвортой хөгжилд хэрхэн чиглэж байгааг (жишээлбэл: байгальд ээлтэй хэрэглээ, орон нутгийн оролцоонд суурилсан төсөл, уур амьсгалд нийцсэн хичээлүүд гэх мэт).

Хүснэгт 1. Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалт зохион байгуулах журмын товчлол

№	Үндсэн бүтэц	Заалтын дугаар	Заалт
1	Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалт зохион байгуулах журмын нийтлэг үндэслэл	1.1	Иргэн бүрийн сурч боловсрох эрх, тэгш хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх албан бус сургалтын хэлбэрийг “Боловсрол нөхөн олгох сургалт”
2	Сургалтын зохион байгуулалт	2.2	Боловсрол нөхөн олгох сургалтыг аймаг, сум, дүүргийн ерөнхий боловсролын сургууль бүлгийн (танхимын, зайны, гэрийн буюу шавь сургалт, түр цугларалт, бие даах) сургалтын хэлбэрээр зохион байгуулна.
3	Сургалт зохион байгуулагчид тавигдах шаардлагад:	2.3.1	2.3.1. Сургалтын төлөвлөгөөг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө”-нд нийцүүлэн боловсруулсан байх;
		2.3.3	Сургалт зохион байгуулах багш нь: - багш мэргэжилтэй, - боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн агуулга, холимог бүлгийн арга зүйн сургалтад хамрагдсан, - зайны сургалт зохион байгуулах мэдээллийн технологийн мэдлэгтэй байх;
4	Сургалтын хэлбэр, хугацааны хувьд:	2.3.3	Сургалтыг суралцагчийн мэдлэг, чадварын түвшин, суралцах боломжид үндэслэн танхимын, зайны, гэрийн буюу шавь сургалт, түр цугларалт, бие даах хэлбэрийн аль нэгээр, эсвэл

			эдгээр аргуудын хосолсон хэлбэрээр зохион байгуулах бөгөөд журмын 4.2-т заасан сургалтын хугацааг баримтална
	Сургалтын явцад хийх хяналт, шинжилгээ, үнэлгээний тухайд:	5.4	Суралцагчийг ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг сургалт зохион байгуулагч ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
		5.5	Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж, төгсөлтийн шалгалт өгөх суралцагчдын дэлгэрэнгүй мэдээллийг сургалт зохион байгуулагч, сургуулийн захиргаа боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн газраар дамжуулан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх ба төгсөлтийн шалгалт өгөх, боловсролын үнэмлэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг бага, дунд боловсролын төгсөлтийн шалгалтын журмаар зохицуулна.

1.2 Их, дээд сургуулиудын хөтөлбөрийн товч танилцуулга

(Хавсралт 4 дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав)

№	Сургууль	“Багш” мэргэжлийн хөтөлбөрийн тоо	Нийт хөтөлбөрт эзлэх хувь	Бусад мэргэжлийн хөтөлбөрийн тоо	Нийт хөтөлбөрт эзлэх хувь	“Багш” мэргэжлийн хөтөлбөрүүдийн нэр
1	МУБИС	39	75%	13	25%	Математикийн багш; Мэдээлэл зүйн багш; Физикийн багш; Газар зүйн багш; Биологийн багш; Эрүүл мэндийн багш; Дүрслэх урлагийн багш; Дизайн зураг зүйн багш; Насан туршийн боловсролын багш; Тусгай хэрэгцээт боловсролын багш; Нийгмийн ухааны багш; Түүхийн багш; Монгол хэл, уран зохиолын багш; Англи хэлний багш; Орос хэлний багш; Хятад хэлний багш; Солонгос хэлний багш; Герман хэлний багш; Орос, англи хэлний багш; Япон, англи хэлний багш; Биеийн тамирын багш; Бага ангийн багш; Хөгжмийн багш; Сургуулийн өмнөх боловсролын багш
2	ОТИС	3	16.6%	15	83.4%	БГХБ-Англи хэл; Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол; Багш, сургуулийн өмнөх боловсрол
3	Хангай дээд сургууль	4	36.3%	7	63.7%	Багш, гадаад хэлний боловсрол; Багш, сургуулийн өмнөх боловсрол; Багш, бага боловсрол
4	МУИС, Зүүн бүсийн сургууль	4	57.1%	3	42.9%	Багш, бага боловсрол; Багш, сургуулийн өмнөх боловсрол; Багш, биеийн тамирын боловсрол; Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол

5	Дархан дээд сургууль	5	45.5%	6	54.5%	Бага ангийн багш; Хөгжмийн багш; Сургуулийн өмнөх боловсролын багш; Математикийн багш; Багш, гадаад хэлний боловсрол
---	----------------------	---	-------	---	-------	--

Монгол Улсын хэмжээнд багш 32 их, дээд сургууль “багш” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилд 16 их, дээд сургууль багш мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж, төгсөлт хийсэн байна. RETEACH төслийн хүрээнд Монгол улсын хэмжээнд буй их, дээд сургуулиудаас Монгол Улсын боловсролын их сургууль, Отгонтэнгэр их сургууль, МУИС-ийн Зүүн бүсийн сургууль, Хангай дээд сургууль, Дархан дээд сургууль гэсэн 5 их, дээд сургуулиуд хамрагдаж байна. Тус төсөлд хамрагдаж байгаа их, дээд сургуулиудын багш бэлтгэх хөтөлбөрийг авч үзвэл: Монгол Улсын Боловсролын Их Сургууль багш мэргэжлийн 39 хөтөлбөр (нийт хөтөлбөрийн 75%), Отгонтэнгэр их сургууль 3 хөтөлбөр (нийт хөтөлбөрийн 16.6%), Монгол Улсын Их Сургуулийн, Зүүн бүсийн сургууль 4 хөтөлбөр (нийт хөтөлбөрийн 57.1%), Хангай дээд сургууль 4 хөтөлбөр (нийт хөтөлбөрийн 36.3%), Дархан дээд сургууль 5 хөтөлбөр (нийт хөтөлбөрийн 45.5%)-өөр тус бүр багшийн мэргэжлийн бакалаврын хөтөлбөрөөр бэлтгэж байна.

ХОЁР. БАГШ БЭЛТГЭЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН НОГООН БОЛОН ДИЖИТАЛ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Дэлхий нийтийн хэмжээнд тулгарч буй гурван үндсэн асуудлын нэг нь уур амьсгалын өөрчлөлт юм ((WEF), 2024). Энэ нь тогтвортой хөгжлийн бүхий л хүрээнд, тэр дундаа хүний эрүүл мэнд, сайн сайхан байдал, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн өсөлт, байгалийн нөөц, биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байна. Иймд дэлхийн хэмжээнд боловсролыг ногооруулах шаардлагатайг дараах бичиг баримтууд илтгэж байна. Үүнд:

- 100 улсын сургалтын хөтөлбөрийн шинжилгээгээр 47% нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар огт дурдаагүй (UNESCO, Getting every school climate-ready. How countries are integrating climate change issues in education., 2021)
- Багш нарын ердөө гуравны нэг нь (33%) өөрийн бүс нутагт уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлж байгааг үр дүнтэй тайлбарлах чадвартай (UNESCO, Getting every school climate-ready. How countries are integrating climate change issues in education., 2021)
- 2021 онд хийсэн судалгаагаар, залуучуудын 70% нь уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн зарчмуудыг тодорхойлох чадваргүй байсан (UNESCO, Youth demands for quality climate change education, 2022)

Харин Монгол улсын хэмжээнд бүх шатны хөтөлбөрийн цахим байдал, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, интернэтийн боломжийн талаар судалгаанууд нэлээд байгаа боловч, цахим сургалтын бэлэн байдал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлс болон хөтөлбөрийн ногоон болон дижитал байдалд хийсэн дүн шинжилгээ талаар судалгаа хомс байна. Иймд багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын хөтөлбөрийн ногоон болон дижитал байдалд дүн шинжилгээ хийж, цахим сургалтын бэлэн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлахыг зорив.

Үүний тулд 2 төрлийн аргаар МУБИС, Отгонтэнгэр их сургууль, Дархан дээд сургууль, МУИС-ийн зүүн бүсийн сургууль, Хангай дээд сургуулийн багш бэлтгэдэг хөтөлбөрүүдэд судалгаа хийлээ.

2.1 “Ногоон хөгжил ба цахимжуулалтын чиг хандлагыг тусгасан багшийн сургалтын хөтөлбөрүүдийн баримт бичгийн шинжилгээ

МУБИС, Отгонтэнгэр их сургууль, Дархан дээд сургууль, МУИС-ийн зүүн бүсийн сургууль, Хангай дээд сургуулийн багш бэлтгэдэг нийт 34 хөтөлбөрийн стандарт/ хөтөлбөрт баримт бичгийн, сургалт мэдээлэл удирдлагын системийн ажиллагаа, цахим бэлэн байдал гэсэн гурван агуулгын дагуу судалгаа авлаа. Баримт бичгийн судалгааг хийхдээ НҮБ-с 2024 оны 12 сард гаргасан “Сургалтын хөтөлбөрийг ногооруулах удирдамж” (UNESCO, Greening curriculum guidance, 2024) -ийн

боловсролыг ногооруулах дараах 4 зарчим болон Дижитал шилжилттэй холбооны нэг зарчмыг нэмэн түлхүүр үгийг ялгаж, T-Lab программ ашиглан түлхүүр үгийг олох замаар судалгаагаа хийлээ. Үүнд:

1. Үйлдэлд суурилсан

- **Чадавхжуулах (Empowering):** Боловсрол нь суралцагчдыг **чадавхжуулах**, тэдний өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мэдлэг, чадвар, үнэт зүйлсийг эзэмшиж, тогтвортой хөгжлийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд шаардлагатай мэдлэгийг олж авахад тусалдаг. Энэ нь суралцагчдын шинжилгээ хийх, харилцааны болон бусад чадваруудыг сайжруулдаг.
- **Суралцагч төвтэй (Learner-centred):** Боловсрол нь суралцагчдыг үйл явцад идэвхтэй оролцуулахад чиглэсэн бөгөөд **шүүмжлэлт, оролцоотой, асуудалд суурилсан, туршлагад суурилсан** аргуудыг ашигладаг. Энэ нь суралцагчдад өөрсдийн амьдралын туршлага, байгаль орчинтой харилцах, өөрийн ойлголтыг бүтээх боломж олгодог.
- **Ажил, мэргэжлээс хамааралтай (Career-related):** Боловсрол нь суралцагчдад ажил, мэргэжлийн сонголт болон ажлын орчинд ашиглаж болох дадал, шинэ санааг боловсруулж, амьдралд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бэлтгэдэг.
- **Хувирган өөрчлөх (Transformative):** Энэ нь хүн төрөлхтний зан үйл, тогтолцоо болон уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн шалтгаануудыг өөрчлөхөд чиглэсэн нийгмийн болон дэлхийн нийтийн хамтын үйл ажиллагаа.

2. **Шударга байдлыг дэмжих** боловсролын зарчмууд нь хүний эрх, тэгш байдал, хамтын амьдралд чиглэсэн агуулгыг тусгадаг. Эдгээр нь суралцагчдыг зөвхөн байгаль орчны асуудлыг ойлгох бус, дэлхий нийтэд шударга, тэгш байдал, хүний эрхийн талаарх ойлголтыг өргөжүүлэхэд чиглэсэн байдаг.

- **Хүний эрхэд суурилсан.** Энэ нь бүх хүн, тэр дундаа хүүхэд, залуучуудын эрхийг хүндэтгэх, эрүүл мэнд, боловсрол, мэдээлэл, тэгш эрх, ялгаварлан гадуурхахгүй байх эрхүүдийг дэмжих зорилготой. Хүний эрхийн хандлагыг боловсролын салбарт нэвтрүүлснээр залуучуудын дунд эрхээ ойлгуулж, өөрсдийн эрхийг хүндэтгэх, бусдын эрхийг зөвшөөрч, эрхийг нь зөрчиж буй хүмүүст дуу хоолойгоо хүргэх чадварыг хөгжүүлдэг.
- **Хүйсийн тэгш байдал.** Боловсрол нь хүйсийн ялгаа, хүйсийн хэвшмэл ойлголтууд нь хэрхэн тэгш бус байдал үүсдэг болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэхэд энэ тэгш бус байдал хэрхэн нөлөөлдөг талаар судалдаг. Энэ нь хүйсийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, дэлхий даяар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хооронд үүсэх ялгааг арилгахад чиглэнэ.

- **Үе хоорондох тэгш байдалд суурилсан.** Энэ нь ирээдүйн хойч үеийн эрх, үүрэг хариуцлагыг хүндэтгэн, одоо үеийн тэгш эрхийг хадгалан, байгаль орчны хариуцлага, нийгмийн тогтвортой байдлыг хамгаалахыг зорьдог.
- **Соёл доторх тэгш байдал.** Энэ нь одоо үеийн нийгмийн бүлгүүд, соёлын хооронд экологийн, эдийн засгийн, нийгмийн шударга байдал, тэгш байдлыг хөгжүүлэх зорилготой. Бүх соёл, олон улсын бүлгүүдэд шударга хандлага хэрэгжүүлснээр, хариуцлагатай байгаль орчны бодлого, нийгмийн тусламжийг дэмждэг.

3. Чанартай агуулга (Quality content)

- **Шинжлэх ухаанд суурилсан (Scientifically accurate):** Агуулга нь уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжилтэй холбоотой нотолгоонд үндэслэсэн болно.
- **Нэн яаралтай буюу тулгамдсан асуудал (Conveys urgency):** Боловсролыг ногооруулах нь өсөн нэмэгдэж буй уур амьсгалын онцгой байдлыг зохистойгоор шийдвэрлэхийн чухлыг онцолдог.
- **Нас болон хөгжлийн хувьд тохирсон (Age- and developmentally-appropriate):** Агуулга нь суралцагчийн нас болон хөгжлийн онцлогт тохирсон байх.
- **Уугуул соёлын нөлөөлөлтэй (Indigenous-influenced):** Уугуул иргэдийн мэдлэг, үзэл баримтлалыг боловсролд, ялангуяа орон нутагт суурилсан уугуул иргэдийн мэдлэгээс тусган оруулдаг.
- **Тэнцвэртэй (Balanced):** Боловсролыг ногооруулах цогц хандлагыг хангахын тулд танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн суралцахуйн хэмжигдэхүүнийг тэнцвэртэйгээр авч үздэг.

4. Цогц/Иж бүрэн бөгөөд уялдаа холбоотой байдал

- **Цогц (Comprehensive):** Энэ нь суралцагчдад албан, албан бус болон амьдралаас авах (жишээлбэл, музей, номын сан) төдийгүй МСҮТ-ийг хамруулан боловсролын бүхий л үе шатад тогтвортой хөгжил болон уур амьсгалын өөрчлөлтийн талаар иж бүрэн, үнэн зөв, нотолгоонд суурилсан, насанд нь тохирсон мэдээллийг үе шаттайгаар олж авах боломжийг бүрдүүлдэг.
- **Насан турш (Lifelong):** Тогтвортой хөгжлийн боловсрол нь бага наснаас эхэлж, дараагийн суралцах үе шат бүр өмнөх сургалтад суурилсан шинэ мэдээллийг бүтээх замаар

үргэлжилдэг. Тогтвортой хөгжлийн боловсролын хөтөлбөр нь спираль бүтэцтэй байж, үе үеийн сургалт хооронд уялдаа холбоо үүсгэдэг.

- Тухайн соёлд нийцсэн, тохирсон **(Culturally relevant and context appropriate)**: Энэхүү үйл явц нь орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн сорилт, шийдлүүдтэй уялдсан суралцахуйн үр дүнг бий болгохоос гадна, тогтвортой хөгжил болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хүмүүсийн сонголтод нөлөөлдөг соёлын тогтолцоо, хэм хэмжээг харгалзан үзэхэд чиглэгддэг.
- Тэгш хамруулах **(Inclusive)**: Боловсролыг ногооруулах нь боловсролын салбар дотор болон гаднаас мэргэжилтнүүд, эцэг эхчүүд, олон нийт, орон нутгийн удирдагчид гэх мэт оролцогч талуудыг бүгдийг хамруулдаг. Тэд уур амьсгалын сорилт, шийдлүүдийг ойлгоход шаардлагатай өөр өөр үзэл хандлага, шинэ чадвар, өмнөх үеийн болон уугуул иргэдийн мэдлэг, туршлагыг авчирдаг.
- Боловсролын эсвэл сургалтын байгууллага бүхэлдээ/бүхлээрээ **(Institution-wide)**: Боловсролыг ногооруулах зарчмууд нь суралцах орчинд бүхэлд нь интеграцчилагдаж , байгууллагын соёл, практикт нөлөөлдөг. Энэ эдгээр зарчим нь боловсролын байгууллагын сургалтын бүхий л хэсэгт ногоон боловсролын үзэл баримтлал, үйл ажиллагааг тусдаг.

Хүснэгт 3. Стандарт, хөтөлбөрийн элемент бүрд харгалзах түлхүүр үг

	Зорилго	Суралцахуйн үр дүн	Агуулга	Арга зүй	Үнэлгээ
1	Тэгш хамруулах	Чадваржуулах	Шинжлэх ухаан	Суралцагч төвт	Ангид суурилсан үнэлгээ
2	Насан турш	Чадамж (комптенц)	Мультимедиа	Хамтран суралцахуй	Том-хэмжээний үнэлгээ
3	Цогц хандлага	Ур чадвар	Хөгжил	Цахим сургалт	Төсөлд суурилсан ажил
4	Үнэт зүйл	Ногоон амьдралын чадвар	Амьдралын хэв маяг	Дотоод соёлд суурилсан	Баримт нотолгоо
5	Тэгш байдал	Хандлага	Судалгаа	Шүүмжлэлт сургалт	Төсөл
6	Суралцагчдыг чадавхжуулах	Тэнцвэртэй	Жендерт суурилсан	Уламжлалт сургалт	Стандарт
7	Цогц	Идэвх	Ялгаатай байдал	Шинэчилсэн суралцахуй	Шударга ёс

8	Үр дүн	Уян хатан чанар	Хүрээлэн буй орчин	Багшлах ухаан	Нийтлэг үнэлгээ
9	Хүмүүнлэг	Шүүмжлэлт сэтгэлгээ	Нийгэм	Медиа ба шинэ технологи	
10	Үйл ажиллагаа	Хүний эрх	Экономи	Асуудалд суурилсан суралцахуй	
11	Чиг хандлага	Ёс зүй	Дижитал		

Ингэхдээ сургууль бүрээс дараах хөтөлбөр, стандартуудыг сонгон авч судалгаандаа ашиглалаа.

Үүнд:

Хүснэгт 4. Хөтөлбөр, стандартын түүврийн мэдээлэл

МУБИС (Хичээлийн стандартууд)		Отгонтэнгэр		Дорнод их сургууль		Дархан дээд сургууль		Хангай дээд сургууль	
Стандарт	№	Хөтөлбөр	№	Хөтөлбөр	№	Хөтөлбөр	№	Хөтөлбөр	№
Дидактикийн хөтөлбөрийн стандартууд	3	Дидактикийн хөтөлбөр	1	Дидактикийн хөтөлбөр	6	Дидактикийн хөтөлбөр	3	Дидактикийн хөтөлбөр	5
Ерөнхий сэтгэл судлал	1	Англи хэл, Монгол хэлний хөтөлбөр	2					Англи хэл	1
Онлайн сургалтын арга зүй	1	Цахим сургалт, дижитал боловсрол, технологийн хэрэглээ	2					Объект хандагч программчлал	1
Бусад хичээлийн стандарт	8	СӨБ-ийн	1					Бусад	1
Нийт	13	Нийт	6		6		3		5
Нийт									33

Эндээс харахад багш бэлтгэж буй төрийн өмчит болон хувийн 5 сургуулийн хөтөлбөрүүдээс сонгогдсон нийт хөтөлбөрийн 50% нь дидактикийн хөтөлбөр, стандарт, ерөнхий суурьт хамаарах

11%, цахим онлайн сургалттай хамааралтай 11% болон бусад хөтөлбөр, стандартууд 28% -г эзэлж байна.

Зураг 1. Их, дээд сургуулиудын хөтөлбөр, стандартын эзлэх жин




Судалгааны мэдээллийг MS-Excel, T-Lab программ хангамж ашиглан шинжилгээ хийсэн.

Баримт бичгийн судалгаа-Хөтөлбөрийн ногоон болон дижитал байдал

Баримт бичгийн судалгааны хувьд МУБИС-ийн хөтөлбөрийн стандарт бүрд хөтөлбөрийн ногоон болон дижитал байдалтай холбоотой түлхүүр үгнүүд дараах давтамжийн дагуу туссан байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Сургуулиудын харьцуулсан график



Зураг 2-с харахад насан турш, үнэт зүйлс, цогц, үр дүн, үйл ажиллагаа, чиг хандлага, чадамж, ур чадвар, хандлага, идэвх, шинжлэх ухаан, хөгжил, судалгаа, нийгэм, цахим сургалт, стандарт, дижитал зэрэг түлхүүр үгс 4 сургуулийн стандарт, хөтөлбөрүүдэд илүү олон давтамжтай байгаа нь харагдаж байна. Сургууль бүрийн хөтөлбөрийн хэмжээнд дээрх түлхүүр үгс давтагдсан байдлыг хавсралтаар оруулав. Дээрх түлхүүр үгсийн давтамжийг “Сургалтын хөтөлбөрийг ногооруулах удирдамж”-тай уялдуулан харвал үндсэн дөрвөн зарчим болон дижиталчлалын түлхүүр үгсийн эзлэх хувийг харж болно.

Монгол улсын хэмжээнд багш бэлтгэдэг 5 их, дээд сургуулийн хүрээнд багш бэлтгэж буй хөтөлбөрүүдэд үйлдэлд суурилсан зарчимд хамаарах түлхүүр үгийн тоо олон байгаа нь хөтөлбөрүүдэд ихэнхдээ үйлдэлд суурилсан зарчмыг хангахуйц агуулга, арга зүй байгаа гэдгийг илтгэж байна (Зураг 3).


Харин цогц/иж бүрэн бөгөөд уялдаа холбоотой байдалтай холбоотой түлхүүр үг нийт 5 сургуулийн 32 хөтөлбөр, стандартад нийт 19 удаа давтагдсан нь анхаарах асуудал болж байна. Ялангуяа уг зарчимд хамаарах цогц, насан турш, тухайн соёлд нийцсэн, тохирсон, тэгш хамруулах, боловсролын эсвэл сургалтын байгууллага бүхлээрээ ажиллах зэрэгт хамаарах агуулга, арга зүй, үнэлгээнээс гадна сургалтын хөтөлбөр, стандартын зорилгод уялдуулах шаардлага байгааг илтгэж байна. Эдгээр үсгийг эрэмбэлэн харвал үйл ажиллагаа гэдэг үг нийт 123, Хандлага гэдэг үг 78 удаа, үр дүн гэдэг үг

77, хөгжил гэдэг үг 55, судалгаа гэдэг үг 39, стандарт гэдэг үг 35 гэх мэтчилэн давагдсанаас насан турш 28, үнэт зүйл 49, чадамж 19, ур чадвар 16, хөгжил 35 болон цахим сургалт зэрэг үгс МУБИС-ийн багш бэлтгэх хөтөлбөрийн стандартуудад олон давтагдсан байгааг T-Lab программын үгсийн холбоо хамаарлыг харах цаашид дэлгэрүүлэн тайлбарлах болно.

Зураг 3. Хөтөлбөрийн ногоон байдлыг илтгэх түлхүүр үгсийн зарчимд харгалзах давтамж




Хөтөлбөр болон стандартад олон давтагдсан үгсээс чадвар, цогц, дижитал, үр дүн гэдэг 4 үгсийг үг хоорондын холбоо хамаарлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:



Зураг 4-с харахад “Чадвар” гэдэг үг нь “Сургалтын хөтөлбөрийг ногооруулах удирдамж”-с ялгасан түлхүүр үг бөгөөд энэ нь “Шударга байдлыг дэмжих” гэсэн 2-р зарчимд харгалзах үг бөгөөд сонгосон хөтөлбөр, стандартуудын хувьд хичээлийн суралцахуйн үр дүн, хандлага, мэдлэг, дадал зэрэг үгтэй хүчтэй хамааралтай бөгөөд бүтээлч, арга, хэрэглээ, стандарт, зорилго зэрэг үгтэй тодорхой хэмжээнд хамааралтай байгаа нь сургалтын хөтөлбөрийн ногоон байдалд гэхээс илүүтэйгээр сургалтын хөтөлбөрийг боловсруулах арга зүйтэй илүү уялдаатай болох нь харагдаж байна. Зураг 5-аас харахад цогц гэдэг үг нь чадамж, Тогтвортой хөгжлийн боловсрол, үнэт, нас зэрэг үгтэй хүчтэй хамааралтай бөгөөд сул хамааралтай үгсээс онцолбол интерактив, ажиллагаанд, батлах, хөгжилд зэрэг үгс байгаа нь хөтөлбөрийн ногоон байдлыг “Чанартай агуулга” зарчимд тодорхой хэмжээнд нийцсэн байна гэж хэлж болохуйц байна.

Зураг 6-аас харахад Дижитал гэдэг үг нь технологи, мэдээллийн, хэрэглээний, цахим, боловсрол зэрэг үгстэй хүчтэй хамааралтай, харин суралцахуйн үр дүн, хамтран, харилцах, илэрхийлэх, хэрэглээ, онолын зэрэг үгстэй хамааралтай байгаа нь хөтөлбөрийн цахим байдалтай холбоотой, дижитал шилжилттэй холбоотой хөтөлбөрийн дижитал байдалтай тодорхой хэмжээнд уялдаж байгааг харуулж байна. “Үр дүн” гэдэг үгийн холбоо үгийг харвал суралцахуйн, хамаарал, таксономын түвшин хоорондын, үнэлгээний аргууд, хичээлийн зэрэг үгтэй хүчтэй хамааралтай ба шалгалт, ажил, шалтгаан, сайжруулахад, хичээлийн суралцахуйн үр дүн, түвшин, учир, үнэлгээний гэдэг үгстэй сул хамааралтай байгаа нь Хөтөлбөрийн ногоон байдлын чанартай агуулга зарчимд нийцэж байгааг илтгэж байна.

Зураг 8. Түлхүүр үгсийн кластер



Зураг 8 буюу Хөтөлбөрийн ногоон байдлыг илтгэх түлхүүр үгсийн Кластераас харахад хөтөлбөрийн зорилго, арга зүй, үнэлгээ зэрэг хөтөлбөрийн элемент бүрд харгалзах үгийн кластер болон багшийн үйл ажиллагаатай холбоотой кластер үүссэн байгаа нь цаашид хөтөлбөрийн ногоон байдлыг илтгэх зарчмуудыг хөтөлбөрийн элемент бүрд судалгааны үндсэн дээр оруулж, интеграцчилах хэрэгцээ үүсэж байгааг илтгэж байна.

2.2 Сургалт мэдээлэл, удирдлагын систем- Хөтөлбөрийн ногоон ба дижитал байдал

Сургалтын удирдлагын систем нь үйл ажиллагааны бүх талыг удирдах боломжтой орчин үеийн технологиудыг санал болгодог бөгөөд сүүлийн жилүүдэд дэлхий нийт сургалтдаа ихээр ашиглах болсон. Иймд судалж буй их, дээд сургуулиудын сургалтын удирдлагын системд бүртгэлтэй дараах дата дээр анализ хийх нь хөтөлбөрийн ногоон байдалтай уялдах давуу талтай болно. Сургалтын удирдлагын систем нь зөвхөн зайнаас суралцах хэрэгцээг хангаад зогсохгүй багш, суралцагчдыг сурч хөгжих боломжийг олгож байдаг чухал ач холбогдолтой учир бид МУБИС, Отгонтэнгэр их сургууль, Дархан дээд сургууль, МУИС-ийн зүүн бүсийн сургууль, Хангай дээд сургуулиудын сургалтын удирдлагын системээс дараах тоо баримтуудыг цуглууллаа.

Хүснэгт 5. Сургалтын удирдлага мэдээллийн системийн мэдээлэл

Файл нэршил	Файл төрөл	МУБИС	Дархан	Дорнод	Отгонтэнгэр	Хангай
MP4 Video	.mp4	4,014	1120		2,290	1861
WinRAR ZIP archive	.zip	30,641	24		18,071	0
Firefox HTML Document	.pdf	27,105	0		35,499	0
PPTX File	.pptx	8,312	0		7,926	0
PNG File	.png	55,779	248	0	10,478	0
WinRAR archive	.rar	72	0	0	50	0
MP3 Format Sound	.mp3	3,293	982		1,943	0
PPT File	.ppt	953	347		741	1382
Office Open XML Document	.docx	6,250	0		0	0
JPG File	.jpg	16,451	387		12,567	0
JavaScript File	.js	6,541	0	0	0	0
SWF File	.swf	4,200	0	0	0	0
Wave Sound	.wav	14	0	0	6	0
		163,625	3,108		89,571	3243

Хүснэгт 3-аас харахад сургуулиудын сургалтын удирдлагын системийн үзүүлэлтээс харахад багш нар өөрсдийн хичээлээ цахим болгох, мэдээлэл байршуулах, мэдээллийг хадгалах зэрэгт системийг идэвхтэй ашиглаж байгаа нь харагдаж байна. Гэвч цаашид цахим хичээлийн тоог нэмэгдүүлэх, хадгалах бодлого гаргаж, шаардлагагүй том файлуудыг устгах эсвэл өөр байршилд шилжүүлэх боловсруулалт хийх болон зураг, архив файлуудыг оновчтой шахах замаар багтаамжийг үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, медиа файлуудыг хадгалах тусгай серверт байрлуулах шийдлийг тодорхойлох, багш нарын цахим ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

2.3 “Багш бэлтгэх хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө”-нд хийсэн шинжилгээ

Магистрын сургалтын төлөвлөгөө

Магистрын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлагатай уялдаж буй байдал, багц цагийн харьцаа

Хүснэгт 6. Төсөлд хамрагдаж буй их дээд сургуулиудын магистрын түвшний хөтөлбөрүүд

	Сургууль	Хөтөлбөр	Нийт багц цаг	Мэргэжлийн суурь хичээлийн багц цаг	Мэргэшүүлэх хичээлийн багц цаг	Эрдэм шинжилгээний багц
1	МУБИС	Насан туршийн боловсрол	35	10	17	8
		Нийгмийн ухааны боловсрол, судалгааны	30	12	9	9
		Нийгмийн ухааны боловсрол, мэргэжлийн	32	12	15	5
		Дизайн, технологийн боловсрол	34	10	16	8
2	ОТИС	Боловсрол судлал, судалгааны	30	15	9	8
		Боловсрол судлал, мэргэжлийн	32	15	14	3
3	МУИС зүүн бүсийн сургууль	Боловсрол судлал	32	15	12	5

Дээрх үзүүлэлтээс харахад тус 3 сургуулийн хэрэгжүүлж буй магистрын сургалтын төлөвлөгөөнүүд нь БШУ-ны сайдын А/147-р тоот тушаалын дагуу мэргэжлийн суурь, мэргэжлийн, эрдэм шинжилгээ судалгааны багц цагуудын хүрээнд төлөвлөлтийг хийсэн боловч А/147-р тоот тушаалын зарим шаардлагын дагуу нарийвчлан сайжруулах хэрэгтэй. Нийт хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлүүдийн хувьд агуулгын давхцал байхгүй. Отгонтэнгэр их сургуулийн Боловсрол судлалын магистрын сургалтын төлөвлөгөөнд хичээлийн хоорондын залгамж холбоог

тодорхойлсон бол бусад сургуулийн сургалтын төлөвлөгөөнүүдэд хичээлүүдийг дурын улиралд судлахаар төлөвлөсөн байна. Мөн сургалтын төлөвлөгөөнүүдээс онол практикийн зохистой харьцааг шууд харах боломжтой байдлаар тодорхойлох шаардлагатай байна.

Хүснэгт 7. Магистрын түвшний хөтөлбөрүүдийн Дижитал болон ногоон ур чадвар, багшлахуйн хичээлийн агуулга, багц цагийн харьцаа

	Сургууль	Хөтөлбөр	Нийт багц цаг	Дижитал агуулга бүхий багц цаг	Ногоон хөгжилд чиглэсэн багц цаг	Багшлахуйтай холбоотой хичээлийн багц цаг
1	МУБИС	Насан туршийн боловсрол	35	4	2	9
		Нийгмийн ухааны боловсрол, судалгааны	30	2	2	0
		Нийгмийн ухааны боловсрол, мэргэжлийн	32	2	5	0
		Дизайн, технологийн боловсрол	34	31	6	4
2	ОТИС	Боловсрол судлал, судалгааны	30	3	1	2
		Боловсрол судлал, мэргэжлийн	32	3	1	8
3	МУИС зүүн бүсийн сургууль	Боловсрол судлал	32	6	3	9

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт хичээлүүдийн нэршилд дижитал агуулга туссан байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд сургалтын төлөвлөгөө тус бүрд 2-6 багц цагийн агуулгыг тусгасан байна. Харин МУБИС-ийн Дизайн, технологийн боловсрол нэртэй хөтөлбөр нь тухайн хөтөлбөрийнхөө онцлогоос хамаарч нийт багц цагийн 86 хувьд нь дижитал технологитой холбоотой агуулга бүхий хичээл судалж байна.

Мөн сургалтын төлөвлөгөөнд ногоон хөгжилтэй холбоотой хичээлийн нэршил, агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд сургалтын төлөвлөгөө тус бүрд 1-6 багц цагийн ногоон хөгжилд чиглэсэн нэршил, агуулга туссан байна.

Тус сургуулиудын магистрын сургалтын төлөвлөгөө дэх багшлахуйтай холбоотой хичээлийн багц цагууд харилцан адилгүй байгаа нь тухайн хөтөлбөрийн онцлогоос хамаарч байна. Багшлахуйтай холбоотой хичээлийн багц цагийн төлөвлөгөөний нийт багц цагт эзлэх хувь нь 6-28 хувьтай байна.

Бакалаврын сургалтын төлөвлөгөө

Бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тавигдах нийтлэг шаардлагатай уялдаж буй байдал, багц цагийн харьцаа

Хүснэгт 8. Төсөлд хамрагдаж буй их дээд сургуулиудын бакалаврын түвшний хөтөлбөрүүд

	Сургууль	Хөтөлбөр	Нийт багц цаг	Ерөнхий суурь хичээлийн багц цаг	Мэргэжлийн суурь хичээлийн багц цаг	Мэргэшүүлэх хичээлийн багц цаг
1	ОТИС	Багш, гадаад хэлний боловсрол	120	26	21	54
		Багш, монгол хэл уран зохиолын боловсрол	120	28	21	54
2	МУБИС	Багш, насан туршийн боловсрол	124	24	25	75
		Багш, дизайн технологийн боловсрол		17	21	70
3	МУИС, Зүүн	Багш, биеийн тамирын боловсрол	126	18	31	65

	бүсийн сургууль					
4	Дархан дээд сургууль	Багш, бага ангийн боловсрол	120	27	37	61
5	Хангай дээд сургууль	Багш, мэдээлэл зүйн боловсрол	127	30	38	55

Сургалтын төлөвлөгөөнүүд БШУ-ны сайдын А/147-р тоот тушаалын хавсралт дахь бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулагдсан. Хичээлийн агуулга, нэршлийн давхцал байхгүй, хичээл хоорондын залгамж холбоо оновчтой, онол практикийн харьцаа зохистой түвшинд хуваарилагдсан байна.

Хүснэгт 9. Бакалаврын түвшний хөтөлбөрүүдийн дижитал болон ногоон ур чадвар, багшлахуйн хичээлийн агуулга, багц цагийн харьцаа

	Сургууль	Хөтөлбөр	Нийт багц цаг	Дижитал агуулга бүхий багц цаг	Ногоон хөгжилд чиглэсэн багц цаг	Багшлахуйтай холбоотой хичээлийн багц цаг
1	ОТИС	Багш, гадаад хэлний боловсрол	120	8	21	54
		Багш, монгол хэл уран зохиолын боловсрол	120	15	21	54
2	МУБИС	Багш, насан туршийн оловсрол	124	8	25	75

		Багш, дизайн технологийн боловсрол		16	21	70
3	МУИС, Зүүн бүсийн сургууль	Багш, биеийн тамирын боловсрол	126	3	31	65
4	Дархан дээд сургууль	Багш, бага ангийн боловсрол	120	5	37	61
5	Хангай дээд сургууль	Багш, мэдээлэл зүйн боловсрол	127	45	38	55

Сургалтын төлөвлөгөөнд хөтөлбөр тус бүрд 3-45 багц цагийн дижитал агуулга бүхий хичээлүүд тусгагдсан байна. Дижитал болон технологийн чиглэлийн хөтөлбөрүүдийн тус агуулгын хичээлүүд илүү өндөр баг цагтай байгаа бол гадаад хэл, биеийн тамир, бага боловсролын хөтөлбөрүүдэд дижитал агуулга бүхий хичээлийн багц цагууд харьцангуй бага туссан байна.

Харин сургалтын төлөвлөгөөнүүдэд ногоон хөгжилд чиглэсэн багц цагууд нийт багц цагаас 21.38 багц цагийг эзэлж байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч хөтөлбөрийн агуулгад нарийн дүн шинжилгээ хийснээр илүү бодитой болно.

Дүгнэлт

1. Монгол Улсын хэмжээнд багш бэлтгэж буй МУБИС, Отгонтэнгэр их сургууль, Дархан дээд сургууль, МУИС-ийн зүүн бүсийн сургууль, Хангай дээд сургуулийн хөтөлбөрт хөтөлбөрийн ногоон байдлыг илтгэх нийт 5 зарчмын 2 зарчим буюу чанартай агуулга, дижитал шилжилтийн хэсэг илэрсэн. Энэ нь цаашид НҮБ-с санал болгож буй “Сургалтын хөтөлбөрийг ногооруулах удирдамж” болон бусад баримт бичгийг тооцон нарийвчлан уялдуулах шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.
2. Магистрын сургалтын төлөвлөгөөнүүдэд 30-35 багц цаг, бакалаврын сургалтын төлөвлөгөөнүүдэд 120-127 багц цагийг судалж байна. Магистрын сургалтын төлөвлөгөөг нийтлэг шаардлагатай илүү нарийвчлалтайгаар нийцүүлэн сайжруулах шаардлагатай байгаа бол бакалаврын сургалтын төлөвлөгөөнүүдийг нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан байна.

3. Магистрын сургалтын төлөвлөгөөнд дижитал агуулга бүхий хичээлийн эзлэх хувь 6-18 хувь, бакалаврын сургалтын төлөвлөгөөнд 2-12 хувь байна. Харин магистрын сургалтын төлөвлөгөөнд ногоон хөгжилд чиглэсэн хичээлийн эзлэх хувь 3.3-17.6 хувь, бакалаврын сургалтын төлөвлөгөөнд 17.5-30 хувь байна. Эдгээрээс харахад магистрын сургалтын төлөвлөгөөнд дижитал агуулга бүхий хичээлийн эзлэх хувь өндөр байгаа бол бакалаврын сургалтын төлөвлөгөөнд ногоон хөгжилд чиглэсэн хичээлийн эзлэх хувь өндөр байна.
4. Цаашид багш хөтөлбөрийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд дижитал болон ногоон ур чадвар олгох хичээлийн агуулгыг нэмэгдүүлэх, тус ур чадварыг олгох тусгайлсан хичээл оруулахаас илүүтэй мэргэжлийн чиглэлийн хичээлүүдээр дамжуулж ногоон болон дижитал ур чадваруудыг эзэмшүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Хавсралт 1. Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал

Хавсралт 2. Гарааны багшийн стандарт

Хавсралт 3. Бага суурь бүрэн дунд боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр сургалт зохион байгуулах журам

Хавсралт 4. Төсөлд оролцож буй 5 их, дээд сургуулийн багш мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулга (МУБИС, ОТИС, Дорнод ИС, Хангай дээд сургууль, Дархан дээд сургууль)

References

- (WEF), W. E. (2024). *Global Risks Report 2023*. Cologny/Geneva.
- Churches, A. (2008). Bloom's Digital Taxonomy. *Research Gate*, 1-44.
- Geert, R. (n.d.). *SPSS TUTORIALS*. Retrieved from www.spss-tutorials.com: <https://www.spss-tutorials.com/spss-factor-analysis-tutorial/>
- Sneed, O. (2016, May 6). *Arizona State University*. Retrieved from <https://teachonline.asu.edu/2016/05/integrating-technology-blooms-taxonomy/>
- Taeho Yu and Jennifer C Richardson. (2016). An Exploratory Factor Analysis and Reliability Analysis of the Student Online Learning Readiness (SOLR) Instrument. *Asynchronous Learning Network*, 120-141.
- UNESCO. (2021). *Getting every school climate-ready. How countries are integrating climate change issues in education*. Paris.
- UNESCO. (2022). *Youth demands for quality climate change education*. Paris.
- UNESCO. (2024, 12). *Greening curriculum guidance*. Paris, France.
- БЕГ. (2022). *Насан туршийн боловсролын салбарын хүний нөөцийн судалгааны тайлан*. Улаанбаатар.
- БСҮХ. (2022). Монголын суралцагчдын цахим сургалтын бэлэн байдлын тандах судалгаа.
- Газар, М. У. (2023 оны 03 29). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. legalinfo.mn: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16758861285151>-ээс Гаргасан
- Яам, Б. Ш. (2022 оны 05 09). Боловсролын Яам: <https://moe.gov.mn/post/118712>-ээс Гаргасан

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАГШ НАРТ ТУЛГАМДАЖ БУЙ СОРИЛТ, БЭРХШЭЭЛ

Багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо нь багш бэлтгэх, багшийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжих үйл явцын нэгдэл байх бөгөөд багшид үндэсний, орон нутгийн, байгууллагын, сонирхлын бүлгийн, багшийн түвшинд дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг.

Аль ч улсын хувьд багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжих, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг хуулийн хүрээнд зохицуулж, багшийн багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх, багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг.

Нөгөөтэйгөөр багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үндэсний түвшинд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, их сургуулийн түвшинд хамтын удирдлагын нэгдэл, багш өөрөө хэрэгжүүлнэ.

хөгжлийг дэмжих тухай хуульд, багш бэлтгэхдээ,

8.1.Орон нутгийн төрийн захиргааны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн багшийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан захиалгаар багш бэлтгүүлэх гэрээг сургууль болон суралцагчтай байгуулж тэтгэлэг олгож болно.

8.2.Засгийн газар хоорондын гэрээтэй орнуудад тэтгэлгээр сургах хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэлд багшийн мэргэжлийг хамруулна.

8.3.Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

8.4.Ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар анги нь туслах багштай байж болно.

8.5.Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна.

Санхүүгийн нөхцөл байдлын хувьд судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь багшийн цалин, урамшуулал амьдралын хэрэгцээг хангах түвшинд хүрэхгүй байгаа нь багшийн ажлын сэтгэл ханамж буурах, мэргэжлээс гарах нөхцөл бүрдэх гол шалтгаан гэж үзэж байна. Цалин хөлсний асуудал нь зөвхөн санхүүгийн асуудал бус, ажиллах орчин, ачаалал, үр дүнтэй шууд хамааралтай байгаа нь судалгаанаас тодорхой харагдаж байна.

Мөн ЕБС-ийн багш нарын хувьд ажлын ачаалал хэт өндөр байдал, хичээлээс гадуурх олон төрлийн нэмэлт ажил, бичиг баримт, арга хэмжээ зохион байгуулах зэрэг нь хичээл заах үндсэн үүрэгт нь сөргөөр нөлөөлж, сургалтын чанарт сүүдэр тусгаж байгааг онцолжээ. Үүний зэрэгцээ төрөөс боловсролын салбарт хэрэгжүүлж буй бодлого, хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал, байнга шинэчлэгдэж буй дүрэм журам, шаардлага зэрэг нь багш нарыг шинэ мэдээлэлд бүрэн хамрагдах, дасан зохицох нөхцөлгүй болгох тал бий. Судалгаанд оролцогчдын тал хувь нь төрийн бодлого, зохион байгуулалт тогтворгүй байгааг “маш их” болон “их” төвшинд тулгамддаг гэж үнэлсэн нь энэ асуудлын ноцтойг харуулж байна.

Хэдийгээр багшийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтууд зохион байгуулагдаж байгаа боловч, судалгаанд оролцогчдын дийлэнх нь эдгээр сургалт нь багшийн бодит хэрэгцээнд нийцдэггүй, практик ач холбогдол багатай гэж дүгнэсэн. Түүнчлэн дижитал болон ногоон боловсролын талаарх ойлголт, ач холбогдлын талаарх хандлага эерэг байгаа ч, үүнийг хэрэгжүүлэх нөхцөл – ялангуяа тоног төхөөрөмж, платформын хүртээмж, цахим сургалтын дэмжлэг зэрэг нь орон нутгийн болон ахмад багш нарын хувьд сул байгааг илтгэж байна.

Иймд багшийн мэргэжлийг дэмжих, хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангахын тулд цалин хөлс, ажлын ачаалал, нийгмийн үнэлэмж, төрийн бодлого, сургалтын орчин, эцэг эхийн хандлага зэрэг олон талт хүчин зүйлд зэрэгцээ бодлого, дэмжлэг үзүүлэх шаардлага бий болжээ. Энэхүү судалгаа нь ЕБС-ийн багшийн мэргэжлийн орчин нөхцөл, тулгамдаж буй бодит асуудлуудыг тодруулж, цаашдын бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд үнэтэй суурь болох боломжтой юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХЭД ОНЛАЙН БОЛОН ЗАЙН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжихэд цахим технологид суурилсан зайн болон онлайн сургалтын эрх зүйн орчны нөхцөл байдал

Багшийн хөгжлийг дэмжих, чадваржуулах талаарх агуулгыг тусгасан 8 эрх зүйн баримт бичигт цахим сургалт, зайн болон онлайн сургалтын талаар тусгагдсан байдлыг товчлон авч үзье.
(Хавсралт №1-ээс дэлгэрэнгүй танилцана уу)

Монгол Улсын “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030 зэрэг сүүлийн үеийн бодлогын баримт бичгүүдэд бүх түвшний боловсролын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлэх шаардлагатай байгааг онцолсон.

- ⇒ Сүүлийн 4 жилд багшийн хөгжлийг дэмжих, сургалт, үйл ажиллагааны хэлбэрүүдэд анхаарсан уялдаа холбоо бүхий эрх зүйн орчин бүрдүүлэхэд анхаарсан баримт бичгүүд батлагдан хэрэгжсэн давуу талууд байна.
- ⇒ Эрх зүйн баримт бичгүүдэд багш мэргэжлийн хөгжлийг дэмжих, сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт багшийг чадваржуулах, хөгжих үйл ажиллагаа, сургалтыг зөвхөн үндэсний, бүсийн, орон нутгийн түвшин дэх боловсролын төрийн байгууллагууд зохион байгуулах боломжтойг дурдсан байна.
- ⇒ Эрх зүйн баримт бичигт багшийн хөгжлийг дэмжих сургалт, зохион байгуулах ажлын хэлбэр, бүтэц зохион байгуулалт зэргийг ерөнхийд нь тусгасан байна.
- ⇒ Эрх зүйн баримт бичигт төрийн байгууллагын оролцоо, дэмжлэгийн асуудлыг авч үзсэн ч багш бие даан хөгжих, өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжих, зайн болон онлайн сургалт зэрэг асуудлыг бүрхгээр тусгажээ.
- ⇒ Багшийн хөгжлийг дэмжих, чадваржуулахад төрийн болон хувийн хэвшлийн их дээд сургууль, байгууллагатай хамтран ажиллах хэлбэр, хүлээн зөвшөөрөх сонголтыг хязгаарласан заалтууд байна. Тухайлбал

БС-ын 2025 оны А 25 тушаал 1 р хавсралт “Цэцэрлэг, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам”

2.9.1 Энэ журмын 2.9 д заасан албан тушаалтны (удирдах ажилтан, ажилтан буюу багшаас албан тушаалтан гэсэн утга бүхий агуулга), мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт,

үйл ажиллагааг зохион байгуулахад холбогдох их дээд сургууль, мэргэжлийн байгууллага, тухайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж болно.” хэмээн үзсэн.

2.9.2 Үндэсний болон орон нутгийн түвшний сургалтыг энэ журмын 2.13 д заасан цахим системээр зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд цахим систем нь нээлттэй, үнэ төлбөргүй байна.

2.9.3 2.13 энэ журмын 2.9 д заасан сургалт үйл ажиллагааны агуулга, зохион байгуулах хуваарийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн 01 дүгээр сарын 30 ны өдрийн дотор Боловсролын ерөнхий хуулийн 12. 12 т заасан цахим системд нээлттэй байрлуулна.

БС-ын 2025 оны А 25 тушаал 2 р хавсралт “Хүүхдийн цэцэрлэг, ЕБС- багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам “

“Энэ журмын 2.13 д заасан сургалтыг (багш, удирдах ажилтан нь жил бүр, төрөлжсөн сургалтад хамрагдах тухай агуулга бүхий заалт) сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалт, арга зүй, хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулж болно” гэсэн байна.

Дээрх заалт хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн их дээд сургуулийн түвшинд төгсөгчдөө чадваржуулах, багш мэргэжлийн хөгжлийг дэмжихэд хамтран ажиллах сургалтыг зохион байгуулж, гэрчилгээг олгох нь тухайн багш, байгууллагын ажлын үзүүлэлтэд нөлөөлөхгүй мэт ойлголт төрүүлж байна.

Хоёр. Багшийн хөгжлийг дэмжих сургалтын агуулга, арга зүйг цахим сургалтын хэлбэрээр зохион байгуулж ирсэн нөхцөл байдлын тойм

Сүүлийн зургаан жилийн хугацаанд ЕБС-ийн багшийн хөгжлийг дэмжих, чадваржуулах сургалт, үйл ажиллагааг цахим хэлбэрээр онлайнд суурилж зохион байгуулахдаа дараах чиглэл, зохион байгуулалтын хүрээтэй байсан байна. (Хавсралт № 1.2 аас дэлгэрэнгүй танилцана уу?)

- ⇒ Багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтыг багшийн ажилласан жилээс хамаарч үндсэн сургалт хэлбэртэй байх бөгөөд танхим, цахим хосолсон хэлбэртэй байна.
- ⇒ Багшийн хөгжлийг дэмжих төрөлжсөн модуль сургалт нь байгууллагаас сургалтын төлбөр шилжигдэх цахим, онлайн аар нэг кредиттэй байна.
- ⇒ Боловсролын төрийн захиргааны төв байгууллага яам, ерөнхий газрууд нь төсвийн хүрэлцээгүйгээс хувийн компаниудын боловсруулсан платформд суурилж багшийн цахим, зайн сургалтыг зохион байгуулж ирсэн. Сүүлийн 3 жилийн хугацаанд 3 төрлийн

платформоор дамжуулж сургалтыг зохион байгуулсан (Moodle.mn Aplus.mn Bagsh.edu.mn)

- ⇒ ЕБС уудын түвшинд багшийн хөгжлийг дэмжих захиалсан цахим сургалтууд нь эрэлт хэрэгцээг тодруулсан агуулга, арга зүйд суурилдаг.
- ⇒ Үндэсний түвшний багшийн хөгжлийг дэмжих цахим сургалт, зайн сургалтууд нь багш нараас авсан санал асуулга, хэрэгцээний судалгаа авахаас илүү бодлого боловсруулагчдын гаргасан агуулгад суурилсан

Гурав. Цаашид дэвшүүлэх санаа:

- ⇒ Багш суралцсан цахим сургалтын эхний болон гарааны үнэлгээ хийх, цаашид хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөт цахим сан, мэдээллийг өгөх сургалтуудад оролцох хүсэлтэй
- ⇒ Багшийн хөгжлийг дэмжих цахим сургалтын үр дүн, онлайн сургалтын хувилбар, үнэлгээний сан зэрэг багш бие даан ажиллах зайн сургалтууд өргөжүүлэх
- ⇒ Цахим сургалт, онлайн сургалтыг зохион байгуулахдаа Компьютерт суурилсан сургалтын онол, дизайныг харгалзах
- ⇒ Багшийн хөгжлийн цахим сургалт нь ажлын цагаар явагддаг тул зарим багш нар сургалтад хамрагдах зав чөлөө гаргахад хүндрэлтэй байх эрсдэлийг тооцох
- ⇒ Багшийн хөгжлийг дэмжих цахимд суурилсан сургалтын чанар, эрх тэгш байдал, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор багш, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, бусад мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд төрийн, төрийн бус, их дээд сургуулиуд байгууллагууд зэрэг боловсролын голлох оролцогч талуудын үүрэг оролцоог нарийвчлан судалж үзэх
- ⇒ Багшийн хөгжилд суурилсан цахим сургалтууд нь оролцогчдын ур чадвар, англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх зэргээр төлөвлөж хэрэгжүүлэх
- ⇒ Багшийн хөгжил, мэргэжлийг дээшлүүлэх сургалтын хэлбэрийг сайжруулах, магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн сургалт зохион байгуулдаг байгууллагуудын мэдээллийн санг бий болгож танилцуулах

\

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1. Монгол улс багш бэлтгэх боловсрол, багшийг чадваржуулах асуудалд бодлого, үйл ажиллагааны хувьд анхааран ажиллаж байна. Боловсролын салбарыг тэргүүлэх салбар хэмээн үзэж УИХ 2025 оны төсвийн 14 орчим хувийг боловсролд зарцуулахаар шийдсэн байна. Цахим (дигитал) шилжилттэй холбоотой зорилтууд урт хугацааны болоод багшийн талаарх бодлогод илүүтэй тусгагдаж хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч багш нарын мэдээлэл, харилцаа, холбооны технологийн чадвар сайжруулах шаардлагатай чадварт орсон хэвээр байна. Тогтвортой хөгжлийн зорилгын биелэлтийг эрчимжүүлэхэд багш боловсролын талаарх төрийн зорилтууд чиглэж байгаа ч ногоон болон дигитал шилжилтийн талаар багшийн бодлогод тусаж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанууд дутмаг байна. Нийт 28 захиргааны хэм хэмжээ тогтоосон актд төслийн зорилго чиглэлтэй холбоотой зүйл заалтууд тодорхой түвшинд тусгагдсан. Гэвч төрөөс багшийн талаар баримтлах нэгдсэн бодлого боловсролын аль ч түвшинд төдийлөн тодорхойлогдоогүй тул өөр хоорондоо зөрүүтэй мэргэшил, чадамжийн хүрээ, тэдгээрийн төрөл ангилал боловсруулагдах, багш мэргэжлийн нэгдмэл байдал алдагдах эрсдэлтэй юм. Тиймээс багш боловсролын бодлого, стандарт, чадамжийн хүрээ болон бусад баримт бичгүүд, үйл ажиллагааг нэгтгэсэн "Багш боловсролын талаар баримтлах арга хэмжээний чиглэл" боловсруулан бодлого зохицуулалтыг нэгтгэн багшийн ногоон болон дигитал ур чадварын талаар тусгах нь зүйтэй байна.

2. Монгол Улсын хэмжээнд багш бэлтгэж буй хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийхэд ногоон байдлыг илтгэх нийт 5 зарчмын 2 зарчим буюу чанартай агуулга, дигитал шилжилтийн хэсэг илэрсэн. Энэ нь цаашид НҮБ-с санал болгож буй “Сургалтын хөтөлбөрийг ногооруулах удирдамж” болон бусад баримт бичгийг тооцон нарийвчлан уялдуулах шаардлагатай бөгөөд хичээл болон арга зүйд суурилсан байдлаар хөтөлбөрүүдэд ногоон болон цахим агуулгыг тусгаж хөтөлбөрийн онцлогт нийцүүлэн турших нь илүү зохистой, илүү нийцтэй арга зүйг сонгох боломж бүрдүүлнэ.

3. Цаашид хөтөлбөрийн чанарын баталгаажилтыг хангах, түүнд тавигдах нийтлэг болон бусад шаардлага, магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад энэхүү агуулга арга зүйн өөрчлөлтийг тусгах боломжтой. Багшийн чадамжийн стандарт, чадамжийн хүрээ зэрэгт ногоон болон дигитал ур чадварыг тусгах,

4. Гарааны багшийн стандартыг үндэсний хэмжээний стандарт болгож сургуулиудад мөрдөх ингэснээр багшийн цахим сургалтын эхний болон гарааны үнэлгээ хийх, цаашид хөгжүүлэх чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах суурь хэмжүүр болох боломжтой юм.

XABCPAJT

Хавсралт №1

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРААС АВСАН АНКЕТЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү судалгаа нь ЕБС-ийн багш нарт тулгарч буй асуудлууд, ногоон болон дижитал боловсролын өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор нийслэлийн 9 дүүргийн 2567 багш, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-сүмбэр, Завхан, Төв, Хэнтий гэх мэт 12 аймгийн 1936 буюу нийт 4503 багшаас санамсаргүй түүврийн аргаар анкетын судалгаа авав. 2024 оны статистик мэдээгээр Монгол Улсын хэмжээнд 37,770 багш ЕБС-д багшилж байна.¹⁴ Үүнээс үзэхэд ЕБС-ийн багш нарын их олонлогийн 11.3%-ийг хамруулсан нь бидний судалгаа төлөөлөх чадвар өндөр байгааг харуулж байна.

Судалгаанд оролцогч багш нарын 13.6% нь эрэгтэй, 86.4% нь эмэгтэйчүүд байгаа нь ЕБС-ийн багш нарын дийлэнх хувь нь эмэгтэйчүүд байдагтай холбоотой юм. Ажилласан жилийн хувьд 16% (n=722) нь 1-3 жил ажилласан буюу шинэ багш нар, 27% (n=1220) нь 4-9 жил, 31.2% (n=1404) нь 10-19 жил, 25.7% (n=1157) нь 20-оос дээш ажилласан туршлагатай багш нар байна.

Судалгаанд хамрагдсан багш нарын 9.4% (n=425) нь 22-25 насны буюу залуу багш нар, 29.7% (n=1337) нь 26-34 насных, 36.2% (n=1631) нь 35-45 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол 21.5% (n=967) нь 46-55 буюу дунд насны багш нар, 3.2% (n=143) нь 56-аас дээш насны ахмад багш нар эзэлж байна. Харин багш нарын хичээл заадаг сурагчдын түвшний хувьд 37.7% нь (n=1680) бага ангийнхан, 50.3% нь (n=2266) дунд анги, 12.4% (n=557) нь ахлах ангийнхан байна. Дээрх багш нарын 26.7% нь өмнө нь дижитал боловсрол, ногоон боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролтой холбоотой төсөл, хөтөлбөрт хамрагдаж байсан бол 73.3% нь ямар нэгэн төсөлд хамрагдаж байгаагүй байна.

1. ЕБС БАГШ НАРЫН НОГООН БОЛОН ДИЖИТАЛ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ногоон боловсролын ач холбогдлыг үнэлэх талаарх асуултад 16% (n=722) нь маш их ач холбогдолтой, 38.8% (n=1748) нь их, 37.2% (n=1673) нь дунд, 5.7% (n=258) нь бага, 2.2% (n=99) нь ач холбогдолгүй хэмээн хариулжээ. Үүнээс харахад ногоон боловсролын ач холбогдлыг багш нар ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч цаашид уг ойлголтыг гүнзгийрүүлэх шаардлагатай байна.

¹⁴ Монгол улсын Үндэсний Статистикийн Хороо, https://www2.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_1

Хүснэгт №1. Заадаг хичээлийн ерөнхий чиглэл, Ногоон боловсролын ач холбогдол

Заадаг хичээлийн ерөнхий чиглэл * ТА НОГООН БОЛОВСРОЛЫН АЧ ХОЛБОГДЛЫГ ҮНЭЛНЭ ҮҮ.
Crosstabulation

Count		ТА НОГООН БОЛОВСРОЛЫН АЧ ХОЛБОГДЛЫГ ҮНЭЛНЭ ҮҮ.					Total
		Ач холбогдолгүй	Бага	Дунд	Их	Маш их	
Заадаг хичээлийн ерөнхий чиглэл	Байгалийн ухаан	20	57	381	447	230	1135
	Нийгмийн ухаан	11	16	144	184	85	440
	Хэл, уран зохиол	18	60	381	378	157	994
	Технологи, мэдээлэл	8	16	110	110	36	280
	Урлаг, спорт	17	31	204	142	61	455
	Бага ангийн багш	25	78	453	486	155	1197
Total		99	258	1673	1747	724	4501

Дээрх асуултын хүрээнд багш нарын заадаг хичээлийн чиглэлийг харьцуулж авч үзвэл байгалийн ухааны болон нийгмийн ухааны хичээл заадаг багш нар ногоон боловсролын ач холбогдлыг илүү их үнэлдэг байна. Энэ нь байгаль орчин, нийгмийн хөгжлийн асуудалтай шууд холбоотой агуулгыг заадаг багш нар ногоон боловсролын үнэ цэнийг илүү гүнзгий ойлгож байгаатай холбоотой байж болох юм. Багш нарын заадаг хичээлийн чиглэлээс шалтгаалан ногоон боловсролын ач холбогдлыг үнэлэх байдал харилцан адилгүй байгаа нь энэ чиглэлээрх мэдлэг, ойлголтыг бүх багш нарын дунд жигд түгээх, сургалтын хөтөлбөрт уялдуулах шаардлагатайг харуулж байна.

Дижитал боловсрол, ур чадварын ач холбогдлыг үнэлэх тухай асуултад судалгаанд оролцсон багш нарын 14.4% (n=650) нь маш их, 45.1% (n=2031) нь их, 36.2% (n=1629) нь дунд, 3.6% (n=162) нь бага, 0.7% (n=31) нь ач холбогдолгүй гэж хариулжээ. Дээрх тоон үр дүнгээс харахад багш нарын дийлэнх олонх (59.5%) нь дижитал боловсрол, ур чадварыг "маш их" болон "их" ач холбогдолтой гэж үнэлсэн байна. Энэ нь боловсролын технологийн хөгжил, дижитал чадварын шаардлага өсөн нэмэгдэж байгаатай уялдаж байгаа нь харагдаж байна. Мөн 36.2% (n=1629) нь "дунд" түвшинд ач холбогдол өгч байгаа нь зарим багш нар дижитал ур чадварыг чухал гэж үзэж байгаа ч бүрэн ухамсарлахгүй байгааг илтгэж байна. Харин 4.3% (n=193) нь "бага" болон "ач холбогдолгүй" гэж хариулсан нь зарим хэсэгт дижитал боловсролын ач холбогдлын талаарх ойлголт дутмаг байгааг харуулж байна.

Хүснэгт №2. Багшийн мэргэжлийн зэрэг болон дижитал ур чадварын ач холбогдол

Correlations

		Та дижитал боловсрол, ур чадварын ач холбогдлыг үнэлнэ үү.	Мэргэжлийн зэрэг
Та дижитал боловсрол, ур чадварын ач холбогдлыг үнэлнэ үү.	Pearson Correlation	1	.007
	Sig. (2-tailed)		.622
	N	4503	4503
Мэргэжлийн зэрэг	Pearson Correlation	.007	1
	Sig. (2-tailed)	.622	
	N	4503	4503

"Та дижитал боловсрол, ур чадварын ач холбогдлыг үнэлнэ үү" болон "Мэргэжлийн зэрэг" гэсэн хоёр хувьсагчийн хоорондын хамаарлыг Pearson корреляцийн коэффициентоор (r) үнэлэхэд корреляцийн коэффициент 0.007 байна, энэ нь маш сул эерэг хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн зэрэг өндөр байх нь дижитал боловсролыг илүү чухал гэж үнэлэхэд нөлөөлдөггүй бөгөөд бүх түвшний багш нар энэ сэдвийг ойролцоо байдлаар үнэлж байна.

Хүснэгт №3. Багш мэргэжлээр ажилласан жил болон дижитал ур чадвар, ойлголт

Correlations

Correlations			
		Та өөрийн дижитал ур чадвар, дижитал боловсролын талаарх ойлголт, мэдлэгийг үнэлнэ үү.	Багш мэргэжлээр ажилласан жил
Та өөрийн дижитал ур чадвар, дижитал боловсролын талаарх ойлголт, мэдлэгийг үнэлнэ үү.	Pearson Correlation	1	-.081**
	Sig. (2-tailed)		.000
	N	4502	4502
Багш мэргэжлээр ажилласан жил	Pearson Correlation	-.081**	1
	Sig. (2-tailed)	.000	
	N	4502	4503

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Судалгаанд хамрагдсан багш нар өөрийн дижитал ур чадвар, боловсролыг үнэлэхдээ 42.6% нь маш сайн болон сайн гэж үнэлсэн бол 37.6% нь дунд, 5 орчим хувь нь муу гэж дүгнэжээ. "Та өөрийн

дигитал ур чадвар, дигитал боловсролын талаарх ойлголт, мэдлэгийг үнэлнэ үү" болон "Багш мэргэжлээр ажилласан жил" гэсэн хоёр хувьсагчийн хоорондын хамаарлыг Pearson корреляцийн коэффициентээр (r) харуулахад -0.081, энэ нь сул сөрөг хамаарал байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, багшийн ажилласан жил нэмэгдэх тусам өөрийнхөө дигитал ур чадвар, боловсролын талаарх үнэлгээ бага зэрэг буурах хандлагатай байна.

Хүснэгт №4. E-Parents, Medle.mn платформууд багш нарын ажлыг хөнгөвчилж чаддаг уу?

Coefficients ^a					
Model	Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
	B	Std. Error	Beta		
1 (Constant)	3.856	.034		112.909	.000
Багш мэргэжлээр ажилласан жил	-.072	.012	-.089	-6.010	.000

a. Dependent Variable: E-PARENTS, MEDLE.MN гэх мэт цахим платформууд багш нарын ажлыг хөнгөвчилж чаддаг уу?

E-parent, Medle.mn гэх мэт цахим платформууд багш нарын ажлыг хөнгөвчилж чаддаг эсэх талаарх асуултад 16.3% (n=734) нь маш их, 39.5% (n=1779) нь их, 39.6% (n=1785) нь дунд гэж үнэлсэн бол 4.5% нь муу эсвэл огт хөнгөвчлөөгүй гэж хариулжээ. Сургалтад ашиглах цахим платформууд нь багшийн ажилласан жилд хэр их нөлөөлж буй тодруулах зорилгоор шугаман регрессийн шинжилгээ хийхэд $B = -0.072$ буюу "Багшийн мэргэжлээр ажилласан жил нэмэгдэх тусам дээрх платформууд тухайн багшийн ажлыг хөнгөвчилж чадахгүй байгааг илэрхийлж байв. Тухайлбал багшийн мэргэжлээр ажилласан жил 1 жилээр нэмэгдэхэд платформуудын хөдөлмөрийг хөнгөвчлөх нөлөө 0.072 нэгжээр буурч байна. Харин $\beta = -0.089$ гэдэг нь платформуудын нөлөөний үнэлгээ сул сөрөг хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, багшийн ажилласан жил нэмэгдэх тусам платформуудын хөнгөвчлөх нөлөө бага байдаг. Энэ нь цахим платформуудын нөлөө багасах хандлагатай байна. Стандарт алдаа (Std. Error) нь 0.012 байгаа нь шинжилгээний үр дүнгийн үнэн зөв, нарийвчлалтай байгааг илтгэж байна. P утга нь $= 0.000$ гарсан нь статистик ач холбогдолтойг харуулж байна. Дээрхээс дүгнэж үзвэл багшийн мэргэжлээр ажилласан жил нэмэгдэх тусам цахим платформууд багш нарын ажлыг хөнгөвчилж чадахгүй байх магадлал өндөр байна.

1. ЕБС-ИЙН БАГШ НАРТ ТУЛГАМДАЖ БУЙ НИЙТЛЭГ АСУУДЛУУД

Багш нарт тулгамдаж буй асуудлуудыг тодруулахдаа Багшийн хөгжлийг дэмжих тогтолцоогүй, Багшийн ёс зүй, нэр хүндтэй холбоотой асуудлууд, Ажлын хэт их ачаалал, Санхүүгийн байдал, цалин хөлс хангалтгүй, Сургалтын орчин, материаллаг хангамж дутагдалтай, Төрийн бодлого, удирдлага, зохион байгуулалт тогтворгүй, Сурагчид, эцэг эхийн хандлага зэрэг асуудлын хүрээнд 43 асуулт боловсруулж, 5 хэмжигдэхүүнээр (шкал) үнэлүүлсэн.

Хүснэгт №5. Асуулгын дотоод нийцлийн шинжилгээ

	Бүтэц	Cronbach's Alpha	Асуултын тоо
P1	Багшийн хөгжлийн дэмжих тогтолцоогүй	0.947	7
P2	Багшийн ёс зүй, нэр хүндтэй холбоотой асуудлууд	0.918	7
P3	Ажлын ачаалал хэт их	0.901	5
P4	Санхүүгийн байдал, цалин хөлс хангалтгүй	0.909	6
P5	Сургалтын орчин, материаллаг хангамж	0.921	5
P6	Төрийн бодлого, удирдлага, зохион байгуулалт	0.942	6
P7	Сурагчид, эцэг эхийн хандлага	0.951	7

Дээрх хүснэгтэд харуулсанчлан тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон бөгөөд 43 асуултын ерөнхий найдвартай байдал 0.964 байна. Энэ нь бидний судалгааны бүлэг тус бүрийн кронбахын альфа (Cronbach's Alpha) 0.90-ээс дээш байгаа нь маш өндөр дотоод нийцэлтэй, найдвартай болохыг илэрхийлж байна.

Хүснэгт №6. Бүлэг тус бүрийн ерөнхий үнэлгээ

	Багшийн хөгжлийн дэмжих тогтолцоогүй	Багшийн ёс зүй, нэр хүндтэй холбоотой асуудлууд	Ажлын ачаалал хэт их	Санхүүгийн байдал, цалин хөлс хангалтгүй	Сургалтын орчин, материаллаг хангамж	Төрийн бодлого, удирдлага, зохион байгуулалт	Сурагчид, эцэг эхийн хандлага
Тулгамддаггүй	19.80%	15.40%	7.70%	7.40%	9.90%	5.20%	4.20%
Бага	19.60%	16.10%	10.30%	10.10%	13.00%	10.70%	8.90%
Дунд	35.40%	35.70%	30.40%	25.70%	32.00%	33.60%	28.00%
Их	17.10%	18.10%	22.50%	18.90%	20.40%	22.30%	21.40%
Маш их	8.10%	14.70%	29.00%	37.90%	24.70%	28.20%	37.50%

Хүснэгтээс харахад ЕБС-ийн багш нарт хамгийн их тулгамддаг асуудал нь Сурагчид, эцэг эхийн хандлага нийлбэр дүнгээр хамгийн өндөр хувийг эзэлж байна. Хоёрдугаарт багш нарын санхүүгийн байдал, цалин хөлсний асуудлыг онцолсон байна. Гуравдугаарт, ажлын ачаалал хэт их гэсэн хариултыг судалгаанд оролцогчид тодотгосон байна. Мөн төрийн бодлого удирдлага, зохион байгуулалтын асуудлууд байна. Дээрх нийтлэг тулгамдаж буй 4 асуудлыг задалж авч үзвэл:

Хүснэгт №7. Багшийн хөгжлийг дэмжих тогтолцоогүй

		Responses		
		N	Percent	Percent of Cases
\$Бүлэг1 ^a	Тулгамддаггүй	6254	19.8%	138.9%
	Бага	6183	19.6%	137.3%
	Дунд	11163	35.4%	247.9%
	Их	5378	17.1%	119.4%

Маш их	2543	8.1%	56.5%
Total	31521	100.0%	700.0%

Багшийн хөгжлийг дэмжих тогтолцоогүй гэсэн асуудлын хүрээнд судалгаанд оролцсон багш нарын цөөнгүй хувь нь энэ асуудал тулгамддаг гэж үзсэн нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Дийлэнх буюу 35.4% нь дунд хариултыг сонгосон нь уг асуудал нь их биш боловч тодорхой хэмжээнд тулгамддаг буюу сул сөрөг хандлага байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл багшийн хөгжлийг дэмжих бодлого дутмаг байна хэмээн дийлэнх багш нар үзэж байна. Энэ хандлага нь багш нарын нас, ажилласан жил, мэргэжлийн зэрэг, хүйс зэрэг хүн ам зүйн хүчин зүйлтэй хамааралгүй буюу нийтлэг тулгамддаг асуудал болох корреляцийн шинжилгээгээр ажиглагдаж байв.

Хүснэгт №8. Багшийн ёс зүй, нэр хүндтэй холбоотой асуудлууд

		Responses		
		N	Percent	Percent of Cases
\$Бүлэг2 ^a	Тулгамддаггүй	4843	15.4%	107.6%
	Бага	5062	16.1%	112.4%
	Дунд	11262	35.7%	250.1%
	Их	5706	18.1%	126.7%
	Маш их	4648	14.7%	103.2%
Total		31521	100.0%	700.0%

Хүснэгт 8-аас харахад 32.8% ийм төрлийн асуудал маш их болон их тулгамддаг гэж хариулсан бол 35.7% нь дунд, 31.5% тулгамддаггүй гэж үзжээ. Үүнээс үзвэл багш нарын дийлэнх нь ёс зүй, нэр хүндтэй холбоотой асуудлыг тодорхой хэмжээгээр мэдэрч байгаа хэдий ч ноцтой тулгамдсан гэж үзэхгүй байна. Тоон дүнгээс харахад багшийн ёс зүй, нэр хүндтэй холбоотой асуудлыг 3 багш тутмын 1 нь уг асуудлыг ноцтой гэж үзэж байна. Энэ нь ёс зүй, нэр хүндийн асуудал зарим орчин, нөхцөлд хүчтэй мэдрэгдэж байгааг илтгэж байна. Тус бүлгийн хүрээнд 7 асуулт

асуусан бөгөөд үүнээс багш мэргэжлийн ач холбогдол, үнэ цэнийг олон нийт дутуу үнэлдэг нь маш хүндрэлтэй (маш их=24.8%, их=20.1) асуудал болж байгаа талаар судалгаанд оролцогчдын 44.9% нь үзсэн. Харин 1/3 буюу 31.9% нь уг асуудал тодорхой хэмжээнд тулгамддаг болохыг онцолжээ. Түүнчлэн олон нийтийн сүлжээнд багш нарын нэр хүндийг гутаах, ёс зүйн асуудал болгон дэвэргэх хандлага нэмэгдэж байгаад багш нар эмзэглэдэг байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 42.3% нь энэ асуудал их тулгамддаг гэж хариулсан бол 31.8% нь тодорхой хэмжээнд асуудал болдог гэж дүгнэжээ. Өөрөөр хэлбэл уг мэргэжлийн нэр хүндийг өсгөх талаар тодорхой хөтөлбөр хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Хүснэгт №9. Ажлын ачаалал хэт их

		Responses		
		N	Percent	Percent of Cases
\$БүлэгЗ ^a	Тулгамддаггүй	1743	7.7%	38.7%
	Бага	2324	10.3%	51.6%
	Дунд	6845	30.4%	152.0%
	Их	5074	22.5%	112.7%
	Маш их	6529	29.0%	145.0%
Total		22515	100.0%	500.0%

ЕБС-ийн багш нарын ажлын ачаалал өндөр байдаг талаар судалгаанд хамрагдагсдын бараг тэн хагас нь буюу 49.5% нь маш их болон их гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 30.4% нь энэ төрлийн асуудал тодорхой хэмжээнд нөлөөлдөг хэмээн дүгнэжээ. Ялангуяа бичиг баримтын ажил, арга хэмжээ зохион байгуулах гэх мэт олон төрлийн нэмэлт үүрэг нь хичээл заах үндсэн ажлын чанарт нөлөөлдөг гэж багш нарын 54.7% нь хариулжээ. Багшийн ачаалалтай холбоотой 5 асуултад судалгаанд оролцогчдын 48-54% нь маш их болон их гэж хариулж, гурван багш тутмын нэг нь энэ асуудал дунд зэрэг тулгамддаг гэж хариулсан нь ажлын хэт их ачаалал нь ЕБС-ийн багш нар тулгарч буй ноцтой асуудлын нэг болоод байна.

Хүснэгт №10. Санхүүгийн байдал хүнд, цалин хөлс хангалтгүй

		Responses		
		N	Percent	Percent of Cases
§Бүлэг4 ^a	Тулгамддаггүй	2006	7.4%	44.5%
	Бага	2725	10.1%	60.5%
	Дунд	6937	25.7%	154.1%
	Их	5116	18.9%	113.6%
	Маш их	10234	37.9%	227.3%
Total		27018	100.0%	600.0%

Судалгаанд оролцогч багш нарын 37.9% нь “маш их” гэсэн хариулсан. Их болон маш их хариултыг сонгосон оролцогчид нийт оролцогчийн 56.8%-ийг эзэлж байна. Судалгааны дүнгээс харахад санхүүгийн хүндрэл бэрхшээл нь багш нарт маш их тулгамддаг байна. “Тулгамддаггүй” гэсэн хариулт маш бага хувьтай байгаа нь энэ асуудал нийтлэг, өргөн тархсан байгааг илэрхийлж байна. Ялангуяа багш нарын цалин бага, амьдралын хэрэгцээг хангахад хүрэлцээгүй байдаг гэсэн асуудалд нь маш их болон их гэсэн хариулт өгсөн багш нар судалгаанд оролцогчдын 67.1%-ийг эзэлж байна. Зөвхөн 3.9% нь энэ төрлийн асуудал тулгамддаггүй гэж хариулжээ. Мөн нийгмийн баталгаа, урамшуулал, санхүүгийн дэмжлэг маш хангалтгүй гэж 61% нь (маш их болон их), 24.8% нь дунд хэмээн хариулжээ.

Хүснэгт №11. Сургалтын орчин, материаллаг хангамж

		Responses		
		N	Percent	Percent of Cases
§Бүлэг5 ^a	Тулгамддаггүй	2240	9.9%	49.7%

Бага	2927	13.0%	65.0%
Дунд	7194	32.0%	159.8%
Их	4603	20.4%	102.2%
Маш их	5551	24.7%	123.3%
Total	22515	100.0%	500.0%

Сургалтын орчин, материаллаг хангамжтай холбоотой бүлэг асуудлуудад 45.1% нь ихээхэн тулгамддаг гэж хариулжээ. Тохиромжтой анги танхим, лаборатори дутмаг байдаг талаар 48.5% нь “маш их” болон “их” гэж хариулсан бол 30.5% нь дунд хэмээн дүгнэжээ. Түүнчлэн компьютер, тоног төхөөрөмж, интернэт сүлжээний хүртээмж хангалтгүй, багшийн дижитал ур чадвараа нэмэгдүүлэх, ажиллах орчин хангалтгүй байдаг талаар багш нар онцолсон байв. Үүнээс харахад багш нарын дижитал ур чадварыг хөгжүүлэхэд нэн түрүүнд тулгамдаж буй асуудал нь технологийн хүртээмж байна. Мөн сургуулийн байршил, өмчийн хэлбэр зэргээс хамаарч материаллаг баазын тэгш бус байдал байгааг багш нар онцолж байснаас гадна ажлын байранд хөгжихөд шаардлагатай тоног төхөөрөмж хангалтгүй байдаг гэж дүгнэжээ.

Хүснэгт №12. Төрийн удирдлага, зохион байгуулалт

		Responses		
		N	Percent	Percent of Cases
\$Бүлэг ^а	Тулгамддаггүй	1175	5.2%	26.1%
	Бага	2405	10.7%	53.4%
	Дунд	7560	33.6%	167.9%
	Их	5025	22.3%	111.6%
	Маш их	6350	28.2%	141.0%

Total	22515	100.0%	500.0%
-------	-------	--------	--------

Төрийн бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудал багш нарт хурцаар тулгамдаж байна. Тодруулбал, 50.5% нь энэ төрлийн асуудал маш их болон ихээр тулгамддаг байна. Харин 33.6% нь энэ чиглэлийн асуудал их боловч тодорхой хэмжээнд тулгарч буйг онцолжээ. Ялангуяа төрөөс боловсролын салбарт үзүүлэх бодлогын дэмжлэг хангалтгүй байдаг гэж дийлэнх хэсэг нь (55.5% нь маш их болон их) үнэлж байв. 35.9% нь энэ асуудлыг дунд зэрэг гэж үнэлгээ өгсөн бол зөвхөн 14.8% нь бага эсвэл энэ асуудал огт тулгамддаггүй гэж хариулжээ. Мөн боловсролын байгууллагуудад хэт их хянах, шалгах байдал их байдаг нь ажлын уян хатан байдалд нөлөөлж байна гэж олонх багш нар үзсэнээс гадна сурах бичиг, сургалтын стандарт байнга өөрчлөгдөж, багш нар шинэ агуулгад дасан зохицоход хүндрэлтэй байдаг талаар 49.5 хувь энэ асуудал маш их болон их гэж үзжээ. Түүнчлэн шинэ бодлого, хуулийн зохицуулалтад дасан зохицоход тусалсан сургалт, семинар хангалтгүйн улмаас мэдээлэл дутах асуудал гардаг байна. Үүнээс дүгнэвэл багш нар боловсролын салбарт төрийн дэмжлэг одоогийнхоос илүү шаардлагатай гэж үзэж байхаас гадна сурах бичгийн стандарт хөтөлбөрийн тогтвортой байдал дутагдаж буйг илтгэж байна.

Хүснэгт №13. Сурагчид, эцэг эхийн хандлага

		Responses		Percent of Cases
		N	Percent	
\$Бүлэг7 ^a	Тулгамддаггүй	1317	4.2%	29.2%
	Бага	2819	8.9%	62.6%
	Дунд	8836	28.0%	196.2%
	Их	6741	21.4%	149.7%
	Маш их	11808	37.5%	262.2%
Total		31521	100.0%	700.0%

Судалгааны 7 бүлэг асуултууд дундаас хамгийн их тулгамдаж буй асуудал нь сурагчид, эцэг эхийн хандлага асуудал дагуулж байна гэж үзжээ. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 58.9% нь уг

асуудлыг “маш их” болон “их” тулгамддаг гэж хариулжээ. Зөвхөн 13.1%-ийн багш нар энэ төрлийн асуудал бага зэрэг эсвэл огт тулгамддаггүй гэж хариулсан. Тус бүлгийн онцлох зарим асуултыг тодруулбал:

Хүснэгт №14. Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ тавих анхаарал

Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдэдээ тавих анхаарал халамж сул байдаг.

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid Тулгамддаггүй	152	3.4	3.4	3.4
Бага	319	7.1	7.1	10.5
Дунд	1071	23.8	23.8	34.2
Их	863	19.2	19.2	53.4
Маш их	2098	46.6	46.6	100.0
Total	4503	100.0	100.0	

Судалгаанд оролцогчдын 3.4 % (n=152) нь эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэдээ тавих анхаарал халамж сул байх асуудал тулгамддаггүй, 7.1% (n=319) нь бага, 23.8% (n=1071) нь дунд, 19.2% (n=863) нь их, 46.6% (n=2098) нь маш их гэж хариулсан байна. Үүнээс харвал багш нарт тулгамдаж буй хүндрэл бэрхшээлүүдийн нэн тэргүүнд эцэг, эх, асран хамгаалагчдын оролцоо дутмаг, хүүхдэдээ тавих анхаарал халамж сул байгаа нь харагдаж байна. Энэхүү асуудал нь хот, орон нутгийн багш нарт нийтлэг тулгамддаг төдийгүй шинэ, залуу багш нарт дээрх асуудал илүүтэй тулгамддаг болох нь кросс анализ хийхэд ажиглагдаж байв.

Хүснэгт №15. Мэргэжлийн зэрэг ба эцэг эхчүүд багшийн ажил, үүрэг, ачааллыг ойлгох байдал

Correlations			
		Эцэг эхчүүд багшийн ажил үүрэг, ачааллыг ойлгодоггүй, хэт өндөр шаардлага тавих хандлагатай.	Мэргэжлийн зэрэг
Эцэг эхчүүд багшийн ажил үүрэг, ачааллыг ойлгодоггүй, хэт өндөр шаардлага тавих хандлагатай.	Pearson Correlation	1	-.059**
	Sig. (2-tailed)		.000
	N	4503	4503
Мэргэжлийн зэрэг	Pearson Correlation	-.059**	1
	Sig. (2-tailed)	.000	
	N	4503	4503

**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Багш нарт тулгамддаг дараагийн асуудал нь эцэг эхчүүд багшийн ажил үүрэг, ачааллыг ойлгодоггүй, хэт өндөр шаардлага тавих хандлагатай байдаг байна. Энэ тухай асуултад нийт судалгаанд оролцсон багш нарын 60 орчим хувь нь уг асуудал тулгамдаж буйг онцолжээ. Дээрх асуудалд багшийн зэрэг буюу заах аргач, зөвлөх, зэрэггүй багш нарын хооронд корреляцийн шинжилгээ хийхэд утга нь - 0.059 буюу сөрөг хамаарал байна. Тодруулбал, мэргэжлийн зэрэг өндөр байх тусам эцэг эхчүүд багшийн ачаалал болон ажил үүргийг ойлгохгүй, хэт өндөр шаардлага тавих хандлага бага байх хандлагатай байна. P-утга (Sig.) = 0.000 нь $p < 0.01$ учир, энэ хамаарал нь статистик ач холбогдолтой гэдгийг илтгэж байна. Эцэг эхчүүд багшийн ажил үүрэг, ачааллыг ойлгодоггүй, хэт өндөр шаардлага тавих хандлага болон Мэргэжлийн зэрэг хооронд сул сөрөг хамаарал байна. Хамаарал нь маш бага, гэхдээ энэ нь статистик ач холбогдолтой хамаарал гэдгээр судалгааны үр дүнг баталгаажуулж байна.

Сөрөг хамаарал байгаа нь мэргэжлийн зэрэг өндөр байх тусам эцэг эхчүүдийн хэт өндөр шаардлага тавих хандлага бага байж магадгүй юм.

Хүснэгт №16. Сурагчдын сахилга бат, ёс суртахууны асуудал

Сурагчдын дийлэнх нь сахилга бат, ёс суртахууны доголдолтой.

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid Тулгамддаггүй	209	4.6	4.6	4.6
Бага	447	9.9	9.9	14.6
Дунд	1395	31.0	31.0	45.5
Их	960	21.3	21.3	66.9
Маш их	1492	33.1	33.1	100.0
Total	4503	100.0	100.0	

Судалгаанд оролцогчдын 4.6 % (n=209) нь сурагчдын дийлэнх нь сахилга бат, ёс суртахууны доголдолтой байх асуудал тулгамддаггүй, 9.9% (n=447) нь бага, 31% (n=1395) нь дунд, 21.3% (n=960) нь их, 33.1% (n=1492) нь маш их гэж хариулсан байна. Дийлэнх багш нар суралцагчдын сахилга бат, ёс зүйн суртахууны доройтлын асуудалтай тулгамдаж байна.

ЕБС-ийн багш нараас авсан тоон судалгааны үр дүнгээс харахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах бодлогын чиглэлүүдийг санал болгож байна. Үүнд:

1. Багшийн санхүүгийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх зүйтэй. Багшийн цалин урамшууллыг нэмэгдүүлэх нь багш нарт тулгарч буй томоохон асуудлыг шийдвэрлэхэд жинтэй хувь нэмэр оруулна. Боловсролын яамнаас зарласан албан ёсны мэдээгээр 4200 багш дутагдалтай бөгөөд үүнээс 2400 орчим нь Улаанбаатар хотод шаардлагатай байгааг онцолсон. Монгол Улсад багшийн дутагдал үүсэж буй нэн тэргүүний шалтгаан нь уг ажлын байрны цалин, хөлс урамшуулал хангалтгүй байгаатай холбоотой юм.

Цалин, урамшуулал хангалтгүй байгаа нь багш нар олноор мэргэжлээрээ ажиллахгүй байгаа үр дагаварт хүргэж улмаар үлдсэн цөөн тооны багш нар илүү өндөр ачаалалтай ажиллах нөхцөл байдалд хүргэж байгаа нь ЕБС-ийн багш нарт тулгарч буй дараагийн тулгамдсан асуудалд хүргэж байна.

2. Багш нарт тулгамдаж буй хамгийн хүндрэлтэй асуудал бол суралцагчид, эцэг эхчүүдийн хандлагын асуудал юм. Эцэг, эхийн хандлагад нөлөөлөх зорилгоор багш-эцэг эхийн харилцааг дэмжсэн мэдээлэл, соён гэгээрүүлэх кампанит ажил зохион байгуулах нь үр дүнтэй юм. Багшийн нэр төрийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх нь бас үр дүнтэй юм.
3. Сургууль дээр хийгддэг давтамж өндөртэй хяналт, шалгалтыг оновчтой болгох, багшийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхээс гадна тэдний дуу хоолойг төрийн бодлогод тусгах нь чухал байна.
4. Монгол Улсын боловсролын салбарын бодлого нь хамгийн тогтворгүй бөгөөд байнга өөрчлөгдөх хандлага ажиглагддаг. Иймд боловсролын салбарын шинэчлэл, хууль эрх зүйн өөрчлөлтийг тогтворжуулах, ойлгомжтой тайлбарлах, мэдээллээр хангах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.
5. Багшийн хөгжлийг дэмжих журамд багшийн мэргэжил дээшлүүлэх цахим сургалтыг албан ёсоор тооцдог болсон төдийгүй Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2021-2030) зэрэг баримт бичигт зайн болон цахим сургалтыг дэмжсэн заалтууд тусгагдсан. Гэвч цахим сургалтын шалгуур, зайн сургалтын стандарт, цахим үнэлгээний нэгдсэн аргачлал байхгүй байгаа нь цахим сургалт дорвитой хөгжихгүй байхад нөлөөлж ирсэн. Иймд цахим сургалттай холбоотой хуулийн хэрэгжилтийн нэмэгдүүлэх, тодорхойгүй аргачлал, шалгуурыг төрөөс тогтоож өгөх нь дижитал сургалт хөгжихөд чухал нөлөө үзүүлэх юм.

Ерөнхий боловсролын сургуулийн багш нараас авсан энэхүү судалгаа нь багшийн мэргэжлийн орчин нөхцөл, ажиллах нөхцөл байдал, мэргэжлийн хөгжил болон ногоон ба дижитал боловсролын өнөөгийн байдлыг олон талаас нь тодорхойлохыг зорьсон.

Судалгаанаас харахад ЕБС-ийн багш нарт тулгамдаж буй нийтлэг, ноцтой асуудлууд нь нэгдүгээрт, эцэг эх, сурагчдын хандлагатай холбоотой зөрчил, хоёрдугаарт санхүүгийн байдал, цалин хөлсний хангалтгүй байдал, гуравдугаарт багшийн ажлын хэт их ачаалал, мөн төрийн бодлого, удирдлагын тогтворгүй байдал зэрэг асуудлууд байна. Судалгаанд оролцогч багш нарын 58.9 хувь нь эцэг эхчүүд багшийн үүрэг хариуцлагыг ойлгодоггүй, хэт өндөр хүлээлт тавьдаг, багшийн алдааг үл зөвшөөрөх хандлагатай байдаг нь багш нарт хамгийн их дарамт үүсгэж байгааг

онцолжээ. Үүний зэрэгцээ багшийн нэр хүнд, ёс зүйн талаарх нийгмийн сөрөг хандлага нь багшийн мэргэжлийн үнэ цэнийг бууруулахад нөлөөлж байна.

Хавсралт №2

МУБИС-н гарааны багшийн чадамжийн хүрээ(стандарт)

МУБИС-н гарааны багшийн чадамжийн хүрээ(стандарт) нь Багшийн хөгжлийг дэмжих хуулийн 8.5, МУБИСн дүрэм-н 4.6.10-г Үндэслэн МУБИС-н захирлын тушаалаар 2024 онд батлагдан тус сургуулийн хэмжээнд хэрэгжиж буй баримт бичиг юм.

Тус стандарт нь нийтлэг үндэслэл; хамрах хүрээ;чадамжийн хүрээ;хэрэгжилт үнэлгээ гэсэн хэсгүүдээс бүрдэж байна. Стандартын чадамжийн хүрээ нь 3 ай,9 стандартын хүрээнд тодорхойлсон мэдлэгийн 33,чадварын 41, үнэт зүйл хандлагын 29 шалгууртай. Стандартын чадамжийн хүрээнд гарааны багшийн дижитал болон тогтвортой хөгжлийн боловсролын талаар мэдлэг, чадвар, хандлагын хэсэгт дараах байдлаар тусгасан байна.

Мэдлэг

- М3.2: Суралцагчийн суралцах хөгжих орчин бүрдүүлэхэд орчин үеийн сургалтын инноваци, дижитал технологи ашиглах боломжийг мэддэг байх
- М3.3: Харилцаанд олон нийтийн сүлжээ,технологийн хэрэгслүүдийг хэрхэн зөв ашиглахаа мэддэг.
- М3.4: Суралцагчдад технологи, олон нийтийн сүлжээг хэрхэн зөв, аюулгүй, үр ашигтай ашиглах талаар зөвлөх мэдлэгтэй
- М5.3: Сургалтын хэрэглэгдэхүүнээ бэлтгэхдээ дижитал технологи, бусад хэрэгслийг хэрхэн ашиглахаа мэддэг.
- М7.1: Эх хэл түүхсоёл, дижитал технологийн мэдлэгтэй байх
- М7.3: Судалгааны баримт мэдээллийг цуглуулах , боловсруулах арга хэрэгслүүд түүнд шардлагатай өргөн хэрэглээний программуудыг мэддэг.

Чадвар

- Ч3.3: Сургалтад дижитал технологи, олон нийтийн сүлжээг багш эцэг эх,асран хамгаалагчийн хяналттай болон хяналтгүйгээр ашиглах боломжуудыг тодорхойлдог
- Ч3.4: Суралцах, хөгжих орчин бүрдүүлэхэд онлайн нөөц, дижитал технологийг үр дүнтэй ашигладаг.
- Ч4.4:Судлагдахууны агуулгыг монгол үндэстний үнэт зүйлс,уламжлал,соёл, тогтвортой хөгжлийн боловсрол, дэлхий, бүс, орон нутгийн тулгамдсан асуудалтай холбон тайлбарладаг.

- Ч5.5:Дижитал контент, загвар, симуляц, сургалтын дижитал хэрэглэгдэхүүн ашигладаг,цахим орчинд сургах,суралцах үйлийг хөтлөн чиглүүлдэг

Хандлага

- Ү4.2:Мэдээллийг олон эх сурвалжаас хайх, түүн тунгаах, шинжлэх ухааны үндэслэлтэй ханддаг.

Хавсралт №3 МУБИС-н Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал

Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал нь МУБИС-н захирлын тушаалаар 2023 онд батлагдан тус сургуулийн хэмжээнд хэрэгжиж буй баримт бичиг юм.

Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал нь үндэслэл; хөтөлбөрийн эрхэм зорилго алсын хараа; зорилго хүрэх үр дүн гэсэн хэсгүүдээс бүрдэж байна.

Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлалын зорилго, хүрэх үр дүн хэсэгт хөтөлбөрөөр дараах төгсөгчийг бэлтгэн гаргахаар тусгасан байна.

- Байнга өөрчлөгдөж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны, эко системд үндэсний зүйлсээ дээдэлсэн, уламжлал, ёс заншлаа бүтээлчээр баяжуулах эерэг хандлага, ёс зүйгээр манлайлагч иргэн
- Үргэлж өсөн нэмэгдэж буй мэдлэг, мэдээлэл, дижитал технологийн орчилд суралцахуйн замналаа өөрөө тодорхойлж эрдэм мэдлэгээ бүтээх тасралтгүй суралцагч

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тухайн мэргэжлийн чиглэлтэй уялдуулан дижитал ур чадварын агуулгыг тодорхойлно гэж тусгасан байна.

Хөтөлбөрт судлагдахуун хоорондын агуулгад тогтвортой хөгжлийн боловсрол, дижитал шилжилт, МХХТ-н хэрэглээний агуулгыг тусгана.

Дижитал шилжилт: МХХТ-н хөгжил, шинэ үеийнхний сонирхол, сурлцах арга барилд нийцүүлэн дижитал шилжилтийн үзэл санааг арга зүйдээ тусгах шаардлагатай гэж үзжээ.

Үүнийг дараах 3 үе шатаар хэрэгжүүлэхийг санал болгожээ. Үүнд

- Сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, хэвлэмэл материалуудыг шинэ үеийнхэн хүлээж авахуйц байдлаар энгийнчлэн дижитал хэлбэрт оруулах ((Digitalization-Converting data into digital format)
- Сургалтын үйл ажиллагааг үр ашигтай явуулахын төлд дижитал технологиор дамжуулан суралцахуйн агуулгыг энгийнээр ойлгжжлахад чиглэсэн интерактив, AR,VR хэрэгслүүд болон төрөл бүрийн аппликэйшн (Digitalization-Adapting digital technologies)
- Суралцагчид бие даан суралцахад шаардлагатай төрөл бүрийн дижитал бүтээгдэхүүн контент боловсруулах (Digital Transformation-Creating digital products for learners)

Хавсралт №4 МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ТУНХАГЛАЛ 2024

“Монголын боловсролын хувирган өөрчлөлт” чуулганаас” Монголын боловсролын тунхаглал 2024”-г гаргасан. Тус тунхаглалд боловсролын цахим шилжилт ба их өгөгдлийн талаар дараах байдлаар тусгасан байна.

- Монголын боловсролын хувирган өөрчлөлтийг эрчимжүүлэхэд цахим технологийг тууштай ашиглана.
- Цахимаар суралцахуйг дэмжих олон талт үйл ажиллагааг хөхүүлэн дэмжинэ.
- Боловсролын их өгөгдлийн санг бүрдүүлэхэд найдвартай, тохиромжтой гэсэн хэмжилтийн зарчимд тулгуурласан чанартай өгөгдөл цуглуулна.
- Их өгөгдөлд тулгуурласан суралцахуйн сайн туршлага, үр дүнгийн мэдээлэл нь суралцагчийн цаашдын боловсрол, ажил, амьдралын замналаа төлөвлөх, хөгжүүлэх эх үүсвэр байна.
- Их өгөгдлийг хиймэл оюун ухаанд суурилан, төлөвлөлтөөс шийдвэр гаргах хүртэлх үйл явцад ёс зүйтэй ашиглана.

Хавсралт №5 цахим сургалттай холбоотой эрх зүйн баримт бичгийн заалтууд

№	Эрх зүйн баримт бичиг заалт	Заалтын агуулга
1	Боловсролын ерөнхий хууль (2023) 3, 12, 13 зүйл	Цахим сургалт, багшийн мэргэжлийн хөгжлийн бүтэц, зохион байгуулалт, эрх үүрэг ⇒ Цахим сургалт түүнтэй холбоотой нэр томьёо тайлбар, багшийн мэргэжлийн хөгжлийн систем, зохион байгуулалт, хэлбэр, багшийн эрх, үүрэг ⇒ Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим систем ⇒ цахим сургалт зохион байгуулах хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн орчин, нөхцөлөөр хангагдах
2	Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хууль (2023) 15, 16 зүйл	<i>Багшийн ажил үүрэг, мэргэжлийн хөгжил:</i> ⇒ Ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлийн бүлгийн үйл ажиллагаанд оролцох, туршлагаа түгээх, зайн, цахим сургалт зохион байгуулах, мэргэшлийн зэрэг ⇒ Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг нэгж, орон нутаг, үндэсний түвшинд зохион байгуулах ⇒ Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулж болох
3	Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018) 5 р зүйл 10 зүйл 11 р зүйл	<i>Багш хөгжих дэмжлэг:</i> ⇒ Багш нь бие дааж хөгжих богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөтэй ⇒ Сонирхлын бүлэг байгуулж, ажиллах, сургалтын байгууллагын жилийн төлөвлөгөөтэй хувийн болон сонирхлын бүлгийн хөгжлийн төлөвлөгөөг уялдуулах ⇒ Багшид үндэсний, орон нутгийн, байгууллагын, сонирхлын бүлгийн, багшийн түвшинд дэмжлэг үзүүлэх ⇒ Ажилласан үр дүнгийн мэдээлэл, хувийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан ажлын гүйцэтгэлийг боловсролын салбарын мэдээллийн системд илгээх
4	СӨБ болон ЕБС ийн багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм (2022) 3 зүйл	Технологийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах хэм хэмжээ ⇒ Суралцагч, хамт олон, эцэг, эх асран хамгаалагч, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай нийгмийн сүлжээ, технологиор дамжуулан боловсролын аливаа харилцаанд оролцох ⇒ Албан үүргээ гүйцэтгэхдээ байгууллагаас зөвшөөрсөн албаны цахим шуудангийн хаягийг ашиглах ⇒ Технологийн дэвшлийн талаар зохих мэдлэгтэй, зүй зохистой хэрэглэх ⇒ Цахим хичээл, контент бүтээх, ашиглахдаа оюуны өмчийн хууль тогтоомжийн зөрчил гаргахгүй байх
5	ЕБ эзэмшүүлэхэд 1 суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, бүрэлдэхүүн	Багшийн хөгжлийн зардал Цахим хэрэглээний зардал

	ЗГ ын 2024 он 53 дугаар тогтоол 2 р хавсралт	
6	БС-ын 2025 оны А 25 тушаал Цэцэрлэг, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам Цэцэрлэг, ЕБС-ийн багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам	Мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны зохион байгуулалт: ⇒ Мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтыг зохион байгуулах хэлбэр, чиглэл, агуулгын хүрээг багшийн ажилласан жилээр гаргах ⇒ Мэргэжил дээшлүүлэх үндсэн, төрөлжсөн сургалтын агуулга ⇒ Цахим гэрчилгээ олгох мэргэжил дээшлүүлэх
7	БС-ын 2024 оны 09 сарын 19 ны өдрийн А95 тушаал ЕБС-ийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам	Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох шалгуур үзүүлэлт ⇒ Мэргэжил арга зүйн дэмжлэг ⇒ Цахим сургалтад оролцох, зохион байгуулах түгээх
8	Багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт	
9	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/14 дүгээр тушаалын хавсралт	2.2.2-т "Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дигитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх"
10	Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал	Багшлахуйд өөрчлөлт хийх онол, арга зүй, сургалтын хэлбэр, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд цахим технологийг ашиглахад баримтлах чиглэл ⇒ Багшлахуй, суралцахуйн нэгдлийг хангах Заахаас илүү суралцахуйд, өрсөлдөхөөс илүү хамтрахад чиглэсэн, олон хэл, цахим технологи ашиглаж шинэ мэдлэг бүтээх, бодит асуудалд суурилсан утга учиртай суралцахуйг дэмжсэн, суралцахуйн баяр баясал, үнэ цэнийг суралцагчдад мэдрүүлэхүйц багшлахуй, суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх; ⇒ Идэвхтэй сургалтын арга зүйг танхимын болон танхимын бус, холимог сургалтад цахим технологитой хослуулан хэрэглэнэ. ⇒ Цахим технологид суурилсан сургалт, төсөлт ажлуудаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь суралцахуйн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлнэ. ⇒ Сургалтын явц, үр дүнг үнэлэх, суралцахуйн анализ хийх арга зүй, цахим системийг хөгжүүлнэ. ⇒ Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурах бичиг, хэрэглэгдэхүүний ашиглалт, багшлахуй ба суралцахуйн үйл явц, ахиц, үр дүнг суралцагч, багш, сургууль, аймаг, дүүрэг, улсын хэмжээнд

		нэгтгэх боломжтой үндэсний нэгдсэн платформтой байна.
--	--	--

Хавсралт №6 Цахимд суурилсан сургалтын зохион байгуулалтын хүрээ

Зохион байгуулалт, чиглүүлэгч байгууллага	Цахимд суурилсан сургалтын зохион байгуулалтын хүрээ	Онцлог	Цахим хаяг
Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (2012 -2019) Багшийн мэргэжлийн хөгжлийн бодлого, сургалтыг хариуцагч Сургалтыг танхимын хэлбэр байсан Ковид-19 цар тахал эхэлснээс хойш сургалтыг цахим хэлбэрт зохион байгуулсан	Багшийн мэргэжлийн хөгжлийг хангах сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт ⇒ багшийн мэргэжлийг зайны сургалтаар дээшлүүлэх мэдээлэл, холбооны технологид суурилсан үндэсний сүлжээг бий болгох; ⇒ цахим сүлжээнд суурилсан сургалтын нээлттэй хэрэглэгдэхүүний үйлчилгээг бий болгох; ⇒ мэргэжлийг дээшлүүлэх төвлөрсөн болон орон нутгийн сургалтыг зохион байгуулах; ⇒ багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хэрэглэгдэх электрон материалыг бэлтгэх;	1,3,5.10 дахь жилдээ ажиллаж буй багш, удирдах ажилтанд чиглэсэн төрөлжсөн сургалт Боловсролын байгууллагын захиалгат сургалт Багш нарт зориулсан модуль сургалтад	Боловсролын захиргааны төрийн байгууллага, их дээд сургуулийн багш нар мэргэшсэн төрийн бус байгууллагаас хамтран сургалт зохион байгуулах Цахим хэлбэр анх Googlemeet Moodle платформ e.surgalt.edu.mn хаягаар сургалтад оролцож буй багш нарт код нэр өгч нэвтрэх
Боловсролын Ерөнхий Газар (2021 оноос) Боловсролын яамны хэрэгжүүлэгч агентлаг, багшийн мэргэжлийн хөгжил, бодлого, сургалт хариуцагч	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилсан модулийн сэдэв зарлах, шаардлага хангасан байгууллага, иргэд оролцож модуль боловсруулах Шалгарсан модуль сургалтыг цахимаар зохион байгуулах	Модуль сургалт зорилтот ба сонголтод 2 түвшин Офлайн, онлайн хичээлийг судалж, шалгалт өгч батламж авах Мэргэжлийн зэрэгт бүртгүүлэх, зайны хэлбэрээр модуль хичээл үзэх	Aplus.mn Платформ Оролцогчид орж сонголт хийх, байгууллагаас төлбөр шилжүүлэх ажил 2021 -2024 2024 оноос нээлттэй тодорхой төлбөр, үнэгүй ашиглах эрхтэй хуудас
	Ерөнхий боловсролын сургуулиуд багш нарын саналаар төр, төрийн бус байгууллага, иргэдтэй гэрээ хийж сургалт, зөвлөх үйлчилгээ авах	Тухайн байгууллагын түвшинд цахим, танхим хосолсон хэлбэр	mind storm “Багш” платформ
	Багш нар өөрсдөө цахим сургалт, хичээл боловсруулах, түгээх Математикийн хичээл боловсруулах, зохиох	Эдүтэн	Eduten
	Цахим хөгжил инновацийн газар Боловсролын Ерөнхий газар Багшийг чадваржуулах цахим сургалт 2023 оноос	Төрийн өмчийн ЕБС ийн багш нар esis.mn, medlee,mn хаягт бүртгэлтэй байх Сурах бичгийг дижитал хэлбэрт оруулах, багш нар цаашид хөгжүүлэх,	Google education, Mozabook, Mozaweb.mn Medlee.mn Medle цахим сургууль

		чадваржуулах цахим сургалт	Нэвтрэх холбоос: www.bagsh.edu.mn Нэвтрэх нэр: Таны ESIS нэвтрэх нэр Таны нууц үг: ESIS нууц үг
Хувийн хэвшилүүдээс санал болгосон сургалт “Адина-тэгш боломж” ТББ Im world Mongolia Aplus	ЕБС аас бие даан сонгох Багш нарыг цахим, зайн сургалтад суралцуулах	ЕБС-ийн багш нарт зориулсан тэгш хамруулах боловсролын цахим платформ	
		AR, VR зэрэг дэвшилтэт технологид суурилсан цахим сургалтын хэрэглэгдэхүүнүүдийн хэмжээг нэмэгдүүлэх сургалт	I m break Im steam Im world Arguin, Aplus.mn Платформ mn

